




МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК

# ҮНДЭСНИЙ ХӨГЖЛИЙН БАНКНУУДЫН ҮҮСЭЛ ХӨГЖИЛ, ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЭДИЙН ЗАСГИЙН ҮҮРЭГ ОРОЛЦОО

---



Улаанбаатар

## АГУУЛГА

I. Үндэсний хөгжлийн банкуудын түүхэн үүсэл, хөгжил4

II. Хөгжлийн банкны зорилго, үйл ажиллагаа6

1. Зорилго:6

2. Хөгжлийн банкны үйл ажиллагаа:6

3. Хөгжлийн банкны чиг үүргүүд7

3.1. Санхүүгийн салбарын хөгжлийн дутагдлыг нөхөх7

3.2. Бизнесийн орчныг сайжруулах10

3.3. Үндэсний хөгжлийн банкуудыг чадавхижуулах13

4. Улс орнуудын хөгжлийн банкуудын зорилго, үйл ажиллагаа13

4.1. Японы хөгжлийн банк13

4.2. Хятадын хөгжлийн банк15

4.3. Солонгосын хөгжлийн банк16

4.4. Казахстаны хөгжлийн банк16

4.5. Африкийн хөгжлийн банк17

4.6. ХБНГУ-ын KfW Хөгжлийн Банк19

4.7. Польшийн Хөгжлийн Банк (BGK)19

III. Хөгжлийн банк оршин тогтнох үндэс20

IV. Засгийн газар, Хөгжлийн банкны харилцаа21

V. Хөгжлийн банкны эдийн засгийн үүрэг23

1. Хөгжлийн банкны эдийн засагт үзүүлэх нөлөөний давуу ба сул тал24

2. Эдийн засгийн мөчлөг дэх Хөгжлийн банкууд25

3. Хөгжлийн банкууд эдийн засгийн зорилтот салбарт үзүүлэх нөлөө27

VI. ХӨГЖЛИЙН БАНКУУДЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА40

VII. ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКУУД ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД УДИРДАЖ БУЙ ЭРСДЭЛҮҮД45

VIII. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ48

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

[Хүснэгт 1. Африкийн хөгжлийн банкны үйл ажиллагаа](#)<sup>18</sup>

[Хүснэгт 2. Улс орнуудын Хөгжлийн банкуудын эдийн засгийн нөлөөний харьцуулалт](#)<sup>29</sup>

[Хүснэгт 3. Хөгжлийн банкуудын эрсдэлийн удирдлагын зорилго](#)<sup>41</sup>

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

[Зураг 1. Үндэсний Хөгжлийн банкуудын түүхэн үүсэл, хөгжил](#)<sup>5</sup>

[Зураг 2. Хөгжлийн банкны үйл ажиллагааны пирамид](#)<sup>6</sup>

[Зураг 3. Хөгжлийн банк Засгийн газрын харилцаа](#)<sup>23</sup>

[Зураг 4. Хөгжлийн банкны эдийн засгийн үүрэг](#)<sup>24</sup>

[Зураг 5. Хөгжлийн банкуудын эрсдэлийн удирдлагын хүрээнд удирдаж буй эрсдэлүүд](#)<sup>47</sup>

## ТОВЧИЛСОН ҮГС

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АҮЯ	Аж үйлдвэрийн яам
БНПУ	Бүгд Найрамдах Польш улс
БНТУ	Бүгд Найрамдах Турк улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад ард улс
ГЗ	Гүйцэтгэх захирал
ДАА	Дотоод аудитын алба
МУХБ	Монгол Улсын Хөгжлийн банк
ОХУ	Оросын Холбооны Улс
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮХБ	Үндэсний Хөгжлийн Банк
УИХ	Улсын Их Хурал
ҮЭД	Үйл ажиллагааг дэмжих хэлтэс
ХОМК	Хөрөнгө оруулалтын менежментийн компани
ХОС	Хөрөнгө оруулалтын сан
ADFIAP	Ази, Номхон Далайн Бүс Нутгийн Санхүүгийн Байгууллагуудын Холбоо
CAPEX	Хөрөнгийн зардал
EBITDA	Элэгдэл хоргодол хүү татварын өмнөх ашиг
GPIF	Японы тэтгэврийн хуримтлалын сан
JICA	Японы олон улсын хамтын ажиллагааны агентлаг
PwC	ПрайсУотерХаус
ROA	Активын хөрөнгийн өгөөж

ROE	Өөрийн хөрөнгийн өгөөж
SCO IBA	Шанхайн Хамтын Ажиллагааны Байгууллагын Банк Хоорондын Нийгэмлэг
WACC	Хөрөнгийн жигнэсэн дундаж өртөг
CAR	Өөрийн хөрөнгийн хүрэлцээ

## I. Үндэсний хөгжлийн банкуудын түүхэн үүсэл, хөгжил

Үндэсний хөгжлийн банкуудын түүхийг авч үзвэл үйлдвэрлэлийн хувьсгалын эхэн үетэй холбогдох ба харин хөгжлийн үе шатуудын хувьд нэгдсэн ерөнхий замнал байхгүй бөгөөд улс орны, бүс нутгийн онцлогоос хамаарч хувьсан өөрчлөгдөж ирсэн.

Хөгжлийн банкууд анх байгуулагдаж эхэлсэн Европт гэхэд улс орон бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегиуд ялгаатай байснаас хөгжлийн банкуудыг томоохон хэдэн улс л анх байгуулж байсан ба 19-р зууны дунд үед Франц, Герман, Италид үйлдвэрлэлийг дэмжих зорилготойгоор Үйлдвэрлэлийн болон Зээлийн банкууд байгуулагдсан. Тэдгээр банкууд шинээр үүсч хөгжиж байгаа үйлдвэрлэлийн салбартаа томоохон хэмжээний санхүүжилтүүдийг өгч байв.

АНУ-д мөн үүнтэй адилаар үйлдвэрлэлийг санхүүжүүлэх ажил улсын түвшинд Худалдааны банк, Үйлдвэрлэлийг банкаар дамжуулан хийгддэг байсан ба эдгээр банкууд зарим талаараа одоогийн хөгжлийн банкны чиг үүрэгтэйгээр ажилладаг байв. Тэдний үндсэн үүргүүд нь тодорхой хэмжээний эрсдэлтэй байж болох боловч ирээдүйд өндөр үр ашигтай шинэ салбарууд буюу барилга, төмөр замын салбарын төслүүдэд санхүүжилт олгох байсан. Харин эдгээр банкуудын хөрөнгийн эх үүсвэр нь дотоодын болон гадаадын хөрөнгийн бирж дээр хувьцаа, бонд гаргах замаар босгож байжээ.

Энэ үед мөн зарим хөгжиж буй орнуудад хөгжлийн банк байгуулагдаж эхлэв. Тухайлбал 19-р зууны эхэн үед Мексик өөрийн хөгжлийн банк болох Banco de avio-г байгуулсан байсан ба энэ банк нь төмөр замын систем болон харьцангуй жижиг үйлдвэрлэлүүд болох хөвөн, торго, төмөр, цаасны үйлдвэрлэлд санхүүжилт олгохоос гадна Европын улс орнуудаас тоног төхөөрөмж худалдан авахад зээл олгож байсан.

1929 оны хөрөнгийн зах зээлийн сүйрлээс шалтгаалан хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх хөрөнгийн хомсдол үүсч, хөгжлийн санхүүжилтийн институциудын хэрэгцээний талаар дахин авч үзэхэд хүрсэн. Зарим улс орнууд хөгжлийн банкуудынхаа үйл ажиллагааг зогсоож байсан бол зарим орнууд чиг үүргийг нь өөрчлөн хөрөнгийн зах зээлийн хөгжлийг хурдасгах чиг үүрэгтэй шинэ хөгжлийн банкиг байгуулах стратеги барьж эхэлсэн. Тухайлбал, хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих зорилгоор 1934 онд Мексикт байгуулагдсан хөгжлийн банк болох NAFIN-ийг энд дурьдаж болно.

Дэлхийн 2-р дайны дараа олон улс орнууд урт хугацаат хөрөнгө оруулалтын төслүүдийг хэрэгжүүлэхдээ улсын сангаар дамжуулан санхүүжүүлж санхүүжилтийн дутагдалыг нөхөх зорилготой Хөгжлийн санхүүжилтийн институциудыг байгуулж эхэлсэн нь одоогийн хөгжлийн банкууд болон хөгжсөн.


Эдгээр банкуудын үйлдвэрлэлийг дэмжих, импортыг орлох үйлдвэрлэлийн бодлого 1960-аад оноос илэрхий өөрчлөгдөж нийгмийн хөгжил, экспортыг дэмжих болон шинэ технологийг хөгжүүлэх зэрэг шинэ чиглэлийн санхүүжилт нэмэгдсэн. Гэвч 1980-аад оны үед санхүүгийн

хямрал, улс төр, засаглалын асуудлуудаас шалтгаалан хөгжлийн банкуудын санхүүгийн багцуудад хүндрэл учирч эхэлсэн ба олон улсын хөрөнгийн институциуд хөгжлийг санхүүжилтийн зуучлагч байгууллагуудад зээл олгохоо эрс багасгасан.

Эдгээр хүндрэл бэрхшээл, өөрчлөлт хувьслын явцад хөгжлийн институциуд хувьчлагдан, зарим нь бүр хаагдсан бол зарим нь тэр дундаа Латин америк, Азийн орнуудынх санхүүгийн орчинд тохирон өөрчлөгдөж, цар хүрээгээ тэлж өргөжсөн байна. Өөрсдийн санхүүгийн үйлчилгээндээ эргэлтийн хөрөнгө, зөвлөх үйлчилгээ, лизинг, даатгал, үйлдвэрлэл эрхлэгчдийн чадавхийг хөгжүүлэх, техникийн туслалцааны үйлчилгээнүүдийг нэмж, томоохон, үндэсний хэмжээний банкууд болж чаджээ. Мөн синдикат зээл, хувьцаа болон хувьцаа хэлбэрийн бүтээгдэхүүн, баталгаа зэрэг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлснээр эдийн засагт эзлэх зээлийн багцын хэмжээгээ тогтвортойгоор нэмэгдүүлэн ажиллаж байна.

Зээлийн үйл ажиллагаанд шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэхээс гадна эдгээр банкуудад бүтцийн болон бодлогын өөрчлөлт гарч, экспорт-импортын санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын банкны үйл ажиллагааны гэх мэтээр салбарлах нь түгээмэл байна. Тухайлбал, Өмнөд Африкийн хөгжлийн банк 1983 онд хөгжлийн санхүүжилтийн үүрэгтэйгээр байгуулагдаж байсан бол 1990-ээд оны сүүлээр санхүүжүүлэгч, зөвлөх болон түншлэлийн гурвалсан чиглэлтэй үндэсний томоохон хөгжлийн институци болсон байна. Мөн Бразилийн хөгжлийн банк нь 1952 онд дэд бүтцийг санхүүжүүлэх үүрэгтэйгээр байгуулагдаж байсан ба дараа нь үйлдвэрлэлийг дэмжих, дараа нь хөрөнгийн үйлчилгээ, санхүүгийн зуучлалын бүтээгдэхүүний чиглэлээр ажиллан өргөн цар хүрээтэй банк болж өөрчлөгдсөн.

**Зураг 1. Үндэсний Хөгжлийн банкуудын түүхэн үүсэл, хөгжил**



## II. Хөгжлийн банкны зорилго, үйл ажиллагаа

### 1. Зорилго:

Ерөнхийдөө хөгжлийг хурдасгах төслүүдэд урт хугацааны санхүүжилтийг олгох гэж тодорхойлогддог боловч дараах байдлаар ангилах боломжтой. Үүнд:

- ✓ **Эдийн засгийн хөгжил** - Хөгжлийн банкууд нь түүхийн хувьд ерөнхийдөө энэ зорилгоор үүссэн байдаг.
- ✓ **Нийгмийн хөгжил** - Нийгмийн хүртээмжийг сайжруулж, тэгш бус байдлыг багасгах гэх мэт
- ✓ **Бүс нутгийн нэгдэл** – Үндэсний тусгаар тогтнол, бүс нутгийн нэгдлийг бататгах гэх мэт илүү өргөн цар хүрээтэй


Чиглэлийн хувьд:

- ✓ **Салбарын** –тодорхой салбарыг дэмжихэд чиглэсэн (ХАА-н, жижиг дунд үйлдвэрийн хөгжилд чиглэсэн гэх мэт)
- ✓ **Олон төрөлт** –хөгжлийг дэмжсэн зээлийн болон зээлийн бус олон төрлийн үйлчилгээг эдийн засгийн олон салбарт үзүүлдэг.
- ✓ **Эксим банкууд** –экспорт-импортын санхүүжилтийн уламжлалт үйл ажиллагааг явуулж худалдааны санхүүжилтийн болон даатгалын үйлчилгээг үзүүлдэг.

### 2. Хөгжлийн банкны үйл ажиллагаа:

1. Санхүүжилт шаардлагатай байгаа төсөл хөтөлбөрүүдийн эдийн засгийн болон нийгмийн хөгжилд үзүүлэх нөлөөллийг судлах, үнэлэх;
2. Хөрөнгө оруулагчдад урт хугацааны зээлэр дамжуулж урт хугацаанд хамтран ажиллах;
3. Эдийн засгийн өсөлтөд чухал шаардлагатай салбарт техникийн туслалацаа үзүүлэх;
4. Санхүүжилтийн үйл ажиллагаанд хурдасгуурын үүргийг гүйцэтгэх, хөрөнгө оруулагчдыг татах;
5. Циклийн эсрэг үйл ажиллагаа явуулах буюу хямралын үед зээл олгох, бүс нутгийн институциудтэй хамтран ажиллах замаар санхүүгийн хямралын сөрөг нөлөөллийг бууруулах.

Зураг 2. Хөгжлийн банкны үйл ажиллагааны пирамид:



Хөгжлийн банкуудын ангилал, чиглэлээс үл хамаараад амжилттай ажиллахад сайн удирдлага, зохистой санхүүжилтийн бүтээгдэхүүнүүд, тогтвортой бодлого, журам, засаглал нөлөөлж байдаг.

Харин банкны тэргүүний, гол үйл ажиллагаа нь дэд бүтцийн санхүүжилт, мөн бусад санхүүгийн механизмууд, бүтээмжтэй бүтцийг дэмжиж өрсөлдөх чадвартай үйлдвэрлэлийн суурь бүтцийг бий болгох юм.

*Дэд бүтцийн санхүүжилт:* Засгийн газрын болон хувийн салбарын нөөцөөр дунд болон урт хугацааны санхүүжилтийг олгох ба энэ нь банкны дийлэнх зээлийн хувийг эзэлдэг. Олон орны хувьд дэд бүтцийн санхүүжилтийг эхний ээлжинд хийх шаардлагатай байдаг боловч бусад үйлдвэрлэлийн бүтцийг дэмжих, нийгмийн салбар, экспортыг дэмжих болон санхүүгийн зуучлалыг хөгжүүлэх зэрэг бусад үйл ажиллагааг орхигдуулж болохгүй.

*Бусад санхүүжилтийн хэлбэрүүд:* Урт хугацааны санхүүжилтийн хамт болон дэмжих хэлбэрээр хийгдэх богино хугацааны санхүүжилт, хувьцаа болон хувьцаа хэлбэрийн санхүүжилт, бондын санхүүжилт, баталгаа, синдикат гэх мэт.

*Бүтээмжтэй бүтцийг дэмжих:* Хөгжлийн стратегийн дагуу бүтцийн өөрчлөлтийг хийхэд болон дотоодын болон олон улсын зах зээл дэх бараа үйлчилгээний өрсөлдөх чадвар, чанарыг сайжруулахад тохиромжтой орчныг бий болгоход дэмжлэг үзүүлэх.

### **3. Хөгжлийн банкны чиг үүргүүд**

#### **3.1. Санхүүгийн салбарын хөгжлийн дутагдлыг нөхөх**

##### **3.1.1. Урт хугацааны санхүүжилт олгох**

Урт хугацааны санхүүжилтийг өмнө нь Засгийн газраас улсын төсөв болон зээл, тусламжаас санхүүжүүлдэг байсан. Өнөө үед хөгжиж буй улс орнууд санхүүжилтийг улсын төсвөөс гадуур, хувийн эх үүсвэрээр бүрдүүлэх болсон ба ихэвчлэн бондын санхүүжилтээр хийгдэж байна. Гэхдээ үүнд банкны салбарын оролцоо байгаа ба Үндэсний хөгжлийн банкууд голлох үүрэгтэй оролцож байна. Үндэсний хөгжлийн банк нь хөгжиж буй болон хөгжсөн улс орнуудын банкны салбарын дотоодын зээлийн хүүгийн ялгааг арилгахад тус болдог.

Урт хугацаат зах зээлийг бий болгох нь тухайн зах зээл нь хөгжилд чухал шаардлагатай гэж үзэж байгаа тохиолдолд хэрэгцээтэй боловч хэрвээ тийм тохиолдолд урт хугацаат хөрөнгө нь хангалтгүй байдаг, макро эдийн засаг нь харьцангуй тогтвортой, хуулийн систем, дүрэм журам, хяналт тогтвортой тохиолдолд энэ нь үр дүнтэй байна.

Урт хугацааны санхүүжилт нь ихэнхидээ дэд бүтцийн салбарт хэрэглэгддэг.

#### **Дэд бүтцийн санхүүжилтийн ач холбогдол**

Дэд бүтцийн салбар нь хөгжиж буй орны хувьд эдийн засаг, нийгмийн хөгжлийн гол хүчин зүйл гэж үздэг ба энэ салбарт урт хугацааны санхүүжилт хамгийн их шаардлагатай байдаг. Дэлхийн банкны судалгаагаар, хөгжиж буй орны хувьд ДНБ-ний 7% орчмыг дэд бүтцийн хөрөнгө оруулалтад зарцуулах шаардлагатай гэсэн байдаг. Дэд бүтцийн урт хугацааны санхүүжилтийг хийхэд мэдээллийн хангалтгүй байдал, барьцаа хөрөнгийн шаардлага, зээлийн баталгаа, компанийн өр төлбөр, хөрөнгийн харьцаа хангалтгүй байх, хууль эрх зүйн орчин, гэрээ байгуулах зардал гэх мэт бэрхшээлүүд тулгарч байдаг ба үүнд Засгийн газрын оролцоо шаардлагатай болдог ба Засгийн газраас урт хугацаат төслийг санхүүжүүлэх орчинг бий болгох, салбарын шинэчлэлтийг хийх хэрэгтэй.

### Дэд бүтцийн санхүүжилт –Хувийн болон улсын нөөцийг ашиглах нь

Дэд бүтцийн санхүүжилт нь хувийн секторын нөөцийг ашиглахтай холбогддог. Туршлагаас харахад, хөгжиж буй орнуудын дэд бүтцийн салбарийн санхүүжилтийн 70%-ийг Үндэсний хөгжлийн банкаар дамжуулан улсаас санхүүжүүлсэн байдаг ба 22% орчим нь хувийн секторын санхүүжилттэй, 8% нь албан ёсны хөгжлийн тусламжаас санхүүжигдсэн байна. Улс орны санхүүгийн нөхцөл байдлаас шалтгаалан Засгийн газраас төслүүдийг санхүүжүүлэхэд хөрөнгө хязгаарлагдмал тул Үндэсний хөгжлийн банкнаас хувийн капиталыг татахад анхааран ажиллах шаардлага гарч байна.

### Сонголтууд

Урт хугацаат санхүүжилтийг хийхэд Үндэсний хөгжлийн банкнаас дараах стратегийн сонголтуудыг хийх шаардлага гардаг. Үүнд:

- Хөгжсөн орнуудын Үндэсний хөгжлийн банкны туршлагаас харахад бага хүүтэйгээр олон тооны зээлдэгчдэд зээл олгодог буюу татаасын хэмжээг бага байлгадаг бол хөгжиж буй орнууд сөрөг хүүтэй зээл буюу их хэмжээний татаас олгодог.
- Урт хугацаат санхүүжилтийг дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдад олгодог ба энэ нь банкны үйл ажиллагаа, эзэмшилд чухал нөлөөл үзүүлдэг. Жишээ нь Ботсваны Үндэсний хөгжлийн банк нь урт хугацаат болон хувьцааны санхүүжилтийг дотоод гадаадын хөрөнгө оруулагчдад олгодог ба банкны зээлийн гуравны нэг нь гадны хөрөнгө оруулагчдын хөрөнгө байдаг.
- Бондын банк зэрэг нөөцийн сангуудын хэлбэрээр үйл ажиллагаа явуулах. Бондын банк нь эрсдлийг багасгах, үйлдвэрлэлийн өсөлтөөс шалтгаалсан зардлын бууралт буюу их бүтээгдхүүн үйлдвэрлэх замаар зардлыг хэмнэх аргыг хэрэглэдэг. Энэ нь уламжлалт Үндэсний хөгжлийн банкнаас ялгаатай ба зах зээл дээр өөрсдийгөө санхүүжүүлж чадах зуучлалын хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулдаг.
- Бусад санхүүгийн хэрэгслийг нэвтрүүлэх –хамтын санхүүжилт, зээлийн шугам, хувьцаа, мезанин санхүүжилт, синдикат гэх мэт.

### **3.1.2. Хөгжилд зориулсан бусад төрлийн санхүүгийн хэрэгслийг нэвтрүүлэх**

### Богино хугацааны санхүүжилт

Үндэсний хөгжлийн банкууд богино хугацааны санхүүжилтийг ихээр хийдэг байсан ба 1970 оны үед эргэн төлөлтийн хэмжээ бага, зээлийг сайн судлаагүйгээс найдваргүй зээл болж байснаас олон хөгжлийн институциуд хүнд байдалд орж эхэлсэн. Богино хугацаат санхүүжилтийн хөгжилд үзүүлэх нөлөөлөл маш бага байв. Тиймээс Засгийн газрын түвшинд үүнийг дэмжихгүй болж, богино хугацааны санхүүжилтийг арилжааны банкууд хийх болсон. Гэвч богино хугацааны санхүүжилтийн санхүүгийн салбарт үзүүлэх нөлөөлөл их юм. Үндэсний хөгжлийн банкууд богино хугацааны санхүүжилтийг олгосоор байгаа шалтгаан нь:

- Дэд бүтцийн салбарыг хөгжүүлэхэд богино хугацааны санхүүжилтийн бүтээгдэхүүнүүд хэрэгцээтэй болдог ба хөгжиж буй орнуудын хувьд энэ нь банкны салбараас санхүүжигдэх боломжгүй байдаг. Үүнд худалдааны санхүүжилт, эргэлтийн хөрөнгө, хувийн зээл, богино хугацаат үнэт цаас багтана.
- Арилжааны банкуудын зээлийн хүүгийн хувь ЖДҮ-ийн хувьд хэт өндөр байдаг.



- Үндэсний хөгжлийн банк болон тухайн орны бичил санхүүгийн байгууллагуудын холбооны судалгаанаас харахад бичил санхүүгийн байгууллагуудын олгодог богино хугацаат санхүүжилт нь Үндэсний хөгжлийн банкны багцад нэмэгддэг.
- Экспортлогч компаниудын хэрэгцээнд тулгуурлан, ихэнх Эксим банкууд тээврийн, барьцааны, эргэлтийн хөрөнгийн богино хугацааны санхүүжилтийг олгодог.

### Үнэт цаасжуулалт, бүтцийн санхүүжилт

Үнэт цаасжуулалт нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад санал болгон дотоодын дунд болон урт хугацаат өрийн зах зээлийг хөгжүүлэх гол хэрэгсэл болдог. Дэд бүтцийн төслийг төр, хувийн хэвшлийн түншлэл хэлбэрээр санхүүжүүлэх арга зам болж болох ба Үндэсний хөгжлийн банк нь хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг хөрөнгө оруулагчдад худалдан санхүүгийн эх үүсвэр босгон төслийг санхүүжүүлнэ.

### Синдикат зээл

Синдикат зээл нь хэд хэдэн банкнаас зээлдэгчид баталгаа гаргасан зээл ба хөгжиж буй орнуудад түгээмэл биш байдаг. Энэ нь банкны зээл, үнэт цаасыг санхүүгийн институциудад хуваарилах боломжийг олгодог бөгөөд эрсдэл, ирээдүйн өгөөжийг мөн хуваадаг. Анх 1970 аад оны дундуур хэрэглэгдэж эхэлсэн ба 1982 оны Мексикийн дефолт болох үед хөгжиж буй орнуудын өрийн дийлэнх хэсгийн синдикат зээл эзэлж байсан ба 1989 онд Мексикийн өрийн бүтцийг шинэчилсний дараа улс орнууд бондын санхүүжилтийг илүүд үзэх болсон.

Өнөө үед зарим олон улсын болон бүс нутгийн хөгжлийн институциудын санхүүгийн үүргийн нэлээдгүй хэсгийг синдикат зээл эзэлж байгаа ба жишээ нь Олон улсын санхүүгийн корпорацийн санхүүжилтийн бараг 13% -ийг эзэлдэг буюу жилд 1 тэрбум гаруй долларын үнийн дүнтэй зээлийг синдикат зээл хэлбэрээр олгодог. Үндэсний хөгжлийн банкуудын хувьд арилжааны банкуудтай хамтарсан синдикат зээл нь төслийн санхүүжилтийн чухал эх үүсвэр болоод байна.

### Хувьцааны болон хувьцаа хэлбэрийн санхүүжилт

Хувьцааны санхүүжилт нь хувьцаа болон баталгааны хэлбэртэй байх ба нэгэнт өгөөжөө өгсөн тохиолдолд санхүүгийн институци нь өөрийн хувьцааг зарж болдог. Хувьцаа хэлбэрийн гэдэгт хөрвөх өр төлбөр, тогтсон эргэн төлөлтийн хуваарьтай хувьцаанд хөрвөх нөхцөл бүхий зээл, уян хатан эргэн төлөлтийн нөхцөлтэй давуу эрхийн хувьцаа ордог.

- Үндэсний хөгжлийн банк - хөгжлийн төсөлд мөнгө зээлдүүлэхийн оронд бизнесийн түнш болж болдог ба энэ нь оруулсан хөрөнгийн хэмжээгээр хувьцаа эзэмшин ашиг хүртэх боломжтой. Үүнийг дараах хэлбэрүүдээр хийдэг:
  - Хувьцааны санхүүжилтэд зориулсан сан бий болгох. Жишээ нь Мексикийн NAFIN 1980-аад оны эхээр хэд хэдэн ийм санг байгуулан хувьцааны хөрөнгө оруулалтыг дэмжсэн. Үүний үр дүнд Мексикийн хөрөнгийн биржийн үйл ажиллагаа мэдэгдэхүйц өссөн.
  - Хувийн салбартай тусгайлан хамтран ажиллах. Жишээ нь Шри Ланкийн Ayojana Fund Management Ltd- 1996 онд Шри Ланкийн Үндэсний хөгжлийн банк, CDC Капитал Партнерсийн хамтын хөрөнгө оруулалтаар байгуулагдсан томоохон хувийн институцийг дурдаж болно.

- Хувьцааны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор хувьцааг зах зээл дээр худалдах. Дотоодын компаниудын хувьцааны багцыг гарган бирж дээр арилжаалснаар Үндэсний хөгжлийн банк нь биржийн үйл ажиллагааг өргөтгөнө.
- Бүс нутгийн хөгжлийн банк- мөн хувьцааны болон хувьцаа хэлбэрийн санхүүжилтийн хэрэглээг нэмэгдүүлэх боломжтой. Азийн хөгжлийн банк нь хөрөнгө оруулалтын тодорхой төслүүдэд хэрэгжүүлсэн.
- Хөгжсөн болон донор орнууд – хэд хэдэн хөгжсөн болон хөгжиж буй орнуудын хувьцааны санхүүжилтийг дэмжих зорилгоор тусгай сангуудыг байгуулсан. Тэдний зорилго нь хувийн хөрөнгийг хөдөлгөх, эргэлтэнд оруулах байдаг.

### Эрсдлийг бууруулах хэрэгслүүд

Гадаадын хөрөнгө оруулагчдын татахын тулд хөгжиж буй орнуудын Үндэсний хөгжлийн банк эрсэл бууруулах хэрэгслүүдийг ашиглах, хугацааг уртасган зардлыг бууруулах шаардлагатай.

#### **3.1.3. Өргөн хүрээг хамарсан санхүүгийн салбарыг бий болгох**

Хүн амын дийлэнх хэсэгт хүртээмжтэй тэдний хэрэгцээнд тохирсон санхүүгийн үйлчилгээг авах боломжтой нөхцлийг бий болгох.

### ЖДҮ-д зориулсан зээлийн үйлчилгээг авах

ЖДҮ эрхлэгчид арилжааны банкны өндөр хүүтэй зээлээр үйл ажиллагаа явуулахад хүндрэлтэй байдаг ба иймээс Үндэсний хөгжлийн банк нь ЖДҮ эрхлэгчдийг дотоодын санхүүгийн зах зээлийн үйлчилгээг авах боломжийг дэмжин ажилладаг.

### Хөдөөгийн хөгжилд зориулсан зээлийн үйлчилгээг авах, орон нутгийн санхүүжилт

Хөдөөгийн хөгжилд зарим бага орлоготой орнуудын Үндэсний хөгжлийн банк онцгой анхааран ажилладаг ба ХАА-н салбарын ажилчдыг санхүүгийн үйлчилгээг авах боломжийг олгодог.

### Бичил санхүүгийн институциуд

Бичил санхүүгийн институциуд нь орлогоос хамаарсан санхүүгийн үйлчилгээ авах тэгш бус байдлыг арилгах зорилготой ба зарим улс орнуудад эрүүл мэнд, боловсролын үйлчилгээний төлбөрийг санхүүжүүлдэг.

## **3.2. Бизнесийн орчныг сайжруулах**

### **3.2.1. ЖДҮ-ийн хөгжлийн дэмжих**

Дотоодын институциуд ЖДҮ-г дэмжих 2 арга байдаг. Эхнийх нь Үндэсний хөгжлийн банкны чадамжийг нэмэгдүүлэх, хоёрдахь нь ЖДҮ-д чиглэсэн Үндэсний хөгжлийн банкныг тусгайлан байгуулах ба хоёрдахь аргын жишээгээр 1990 онд Энэтхэгт байгуулсан Жижиг үйлдвэрлэлийн хөгжлийн банкныг дурдаж болно. Дээрх 2 аргын аль нь ч байсан бага хүүтэй зээлээр ЖДҮ-г шууд болон санхүүгийн институциер дамжуулан санхүүжүүлдэг. ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих энэхүү зорилтдоо хүрэхийн тулд харилцагчид чиглэсэн стратегийг баримталж үйлчилгээний чанарыг сайжруулах шаардлагатай.

### Санхүүгийн механизм

Олон төрлийн санхүүгийн механизмаар ЖДҮ-г дэмжиж болох ба үүнд ажлын капиталын зээлээс эхлээд лизинг, гадаад валютын зээл, хувьцааны туслалцаа зэрэг байж болдог. ЖДҮ-г санхүүжүүлэх жишээ нь жижиг төслүүдийн хувьд хамтын санхүүжилтийн болон хувьцааны санхүүжилтийн схемийг гаргах, барьцаа хөрөнгийн дутагдалтай төслүүдийн хувьд батлан даалтын сан зэрэг байж болдог. Хамтын санхүүжилтийн механизмын хувьд Үндэсний хөгжлийн банк салбар компани байгуулж болох ба хувьцааны санхүүжилтийн хувьд Үндэсний хөгжлийн банк шууд зээл олгохын оронд компанийн хувьцааг худалдаж авдаг.

### Баталгааны механизм

Өнгөрсөн хугацаанд олон батлан даалтын сангууд алдаатай менежментийн улмаас дампуурч байсан түүхтэй ба Үндэсний хөгжлийн банкны менежмент, ЖДҮ-тэй харилцах харилцааг ашиглан батлан даалтын санг Үндэсний хөгжлийн банкаар дамжуулан батлан даалтын сангийн схемийг байгуулах нь арилжааны банкуудаар дамжуулснаас илүү үр дүнтэй байж болох юм. ЖДҮ-д зориулсан баталгааны механизм нь ялангуяа экспорлогч компаниудад хэрэгтэй байдаг. Механизм нь экспортын даатгалын агентлаг, эсвэл Үндэсний хөгжлийн банкиг оролцуулсан бүтэцтэй байж болдог. Үүнд экспортлогчийн дефолтын үед зээлдэгчид төлбөрийн баталгааг гаргах, эсвэл гадаадын худалдан авагч тал төлбөрийн дефолт болсон үед экспортлогчид нөхөн төлбөрийг олгох хэлбэртэй байж болно.

### Техникийн туслалцаа

Хөгжлийн үүрэг зорилгоо бүрэн хэрэгжүүлэхийн тулд Үндэсний хөгжлийн банкууд ЖДҮ-д зориулсан хөгжлийн сургалт, зөвлөх үйлчилгээг үзүүлж ирсэн. Техникийн туслалцааны гол чиглэл:

- Төслийн хөгжил –төслийг төлөвлөх, хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх. Төслийн хөгжлийн зардал буюу үнэлгээ, ТЭЗҮ, байгаль орчны үнэлгээний зардал зэрэгт баталгааг хэрэглэж болдог.
- Сургалт- санхүүгийн удирдлага төлөвлөлт, бусад удирдлагын ур чадварын сургалт

### **3.2.2. Тогтворгүй байдлыг багасгах**

Хөгжиж буй орны хувьд, капиталын орох урсгал нь макро эхийн засгийн тэлэх бодлоготой холбогддог ба капиталын гадагшлах урсгалын хувьд эсрэгээр байдаг. Энэ цикл нь дүрэм журам, НББ-ын стандарт, санхүүгийн систем, макроэдийн засгийн тогтвортой байдлыг сайжруулахыг шаардаж байдаг. Харин Үндэсний хөгжлийн банкнаас оруулж болох хувь нэмэр нь:

- Зах зээлийн мэдээллийг түгээх-хямралын үед хамгийн ашигтай төсөл хэрэгжүүлэгч ч санхүүжилт олоход хэцүү байх ба эдийн засаг сэргэсэн үед сайн муу бүхий л түвшний компаниуд санхүүжилт авах боломжтой болдог ба энэ нь өөрөө эдийн засагт түлхэц болдог.
- Эдийн засгийн уналтын үед зээлийг нэмэгдүүлснээр Үндэсний хөгжлийн банк нь зээлийн мөчлөгийг тэгшитгэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Төв банк бодлогын хүүгийн түвшинг өөрчлөн мөчлөг сөрсөн бодлогыг барьж эдийн засагт нөлөөлдөг бол хөгжиж буй орнуудын төрийн эзэмшлийн банкуудын олгож буй зээл нь арилжааны банкны зээлийг бодвол мөчлөгийн чанартай биш гэдэг утгаар Үндэсний хөгжлийн банк нь мөн эдийн засагт нөлөөлөх боломжтой юм.

### **3.2.3. Хурдасгуурын үүргийг гүйцэтгэх**

#### Хувийн хэвшлийн хөрөнгийг татах

Өмнө дурдсанчлан хөгжиж буй орнууд ДНБ-ийн 5% орчмыг дэд бүтцийн хөрөнгө оруулалтад зарцуулах шаардлагатай байдаг. Бага орлогтой орнууд ийм хэмжээний санхүүжилтийг дангаараа босгож чадахгүй ба үүнд хувийн салбарын оролцоо шаардлагатай болдог. Үүнд Үндэсний хөгжлийн банкууд санхүүгийн гадаад эх үүсвэрийг татаж дэмжлэг үзүүлэх боломжтой байдаг.

Томоохон дэд бүтцийн төслийг санхүүжүүлснээр Үндэсний хөгжлийн банк нь их хэмжээний эрсдлийг өөртөө авчирдаг. Хувийн санхүүжилтийг татан ашигласнаар эрсдлийг хуваах боломжтой болох юм. Үндэсний хөгжлийн банкны хурдасгуурын үүргийн гол ач холбогдол нь гадаад хөрөнгө оруулагчдын татан эх үүсвэрийг төрөлжүүлж эрсдийг багасган, дэд бүтцийн төслүүдийг тогтвортой хэрэгжүүлэхэд оршдог.

- Харилцаа холбоог нэмэгдүүлэх –дэд бүтцийн төслийн амжилттай хэрэгжих нөхцөл нь төсөл дангаараа биш хөгжлийн төлөвлөгөөний хэсэг байх юм. Үүний тулд салбарыг судалж, эдийн засаг, нийгмийн үр ашгийг хамгийн өндөр байлгах судалгааг хийх хэрэгтэй.
- Хөрөнгө оруулалт хийх-төсөлд оролцох шийдвэр гаргахаас өмнө дотоодын хөрөнгө оруулагчид гадны хөрөнгийн болон технологийн эх үүсвэртэй холбоо тогтоох, гадны хөрөнгө оруулагчид улс төр, зээлийн, валютын ханшийн эрсдлийн талаар мэдлэгтэй байх хэрэгтэй. Сүүлийн жилүүдэд зарим Үндэсний хөгжлийн банк энэ тал дээр анхааран ажиллах болсон:
  - хөрөнгө оруулагчдыг татах улс орны имижийг сайжруулах - Лисоттогийн үндэсний хөгжлийн корпораци Лисоттог дотоод гадаадын хөрөнгө оруулагчдыг татах хөрөнгө оруулалтын бүс болгон хөгжүүлэх үүрэгтэй ажилладаг.
  - баталгааны механизм – зээлийн чанарыг батлан даалтын сан, хамтын хөрөнгө зэргээр сайжруулах
  - ахисан түвшний санхүүгийн механизмууд- зээл, барьцаагүй бонд, өр, хувьцаа зэрэг нь хөгжиж буй орны зарим төслийн хувьд боломжгүй буюу хэтэрхий үнэтэй тусах нь бий. Энэ тохиолдолд Үндэсний хөгжлийн банк бүтцийн санхүүжилтийн хэлцлүүдийг санал болгож болдог. Үүнд багцын үнэт цаасжуулалт, хөрвөх бонд, дуудах эрхтэй бонд гэх мэт механизмууд байж болдог.

#### Төр хувийн хэвшлийн түншлэл

ТХХТ гэдэг нь Засгийн газраас хариуцдаг байсан дэд бүтцийн хөрөнгө, үйлчилгээг хувийн салбарт хариуцуулах зохицуулалтыг хэлнэ. Хувийн хэвшлүүд концессийн гэрээгээр дамжуулан хөрөнгө оруулалт хийх боломжтой ба ингэхдээ санхүүгийн үүргийг хуваах ба санхүүгийн эрсдэл нь хувийн хэвшилд шилждэг.

Төр хувийн хэвшлийн түншлэл нь дэд бүтцийн санхүүжилтэнд түгээмэл хэрэглэгдэх болоод байгаа ба хөгжиж буй орнуудаас Мексик, Чили зэрэг улсууд хувийн хэвшлийн оролцоог дэмжин ТХХТ-г анх хэрэглэж эхэлсэн. Үндэсний хөгжлийн банкууд ТХХТ-г эрсдлийг дамжуулах, том хэмжээний санхүүжилтийг хөгжиж буй орнуудад хэрэгжүүлэхэд ашиглаж болдог.

ТХХТ нь хууль эрхзүйн зохистой орчинтой байх, Засгийн газраас хариуцлагатай байдлыг шаарддаг ба зохистой санхүүжилтгүйгээр шинэ өр төлбөр үүсгэхийг хязгаарлах зэрэг хязгаарлалтууд байдаг.

#### Бүс нутгийн нэгдэл

Үндэсний хөгжлийн банк нь бүс нутгийн болон олон улсын институциудад нэгдэн хурдасгуурын үүргийг гүйцэтгэж, улсын, бүс нутгийн, орон нутгийн чанартай төслүүдийг хэрэгжүүлдэг. Цаашилбал бүс нутгийн хөгжлийн банкууд бусад хөгжлийн банкуудтай нэгдэж болох ба үүний жишээ нь Исламын хөгжлийн банк юм. Исламын хөгжлийн банк нь Үндэсний хөгжлийн банкуудтай харилцаа холбоогоо өргөжүүлэн санхүүжилтийн шугамыг өргөтгөсөн. Үүнд төслийн зөвшөөрөгдсөн санхүүжилтийн дүнгийн 25% хүртэлх дүнтэй чөлөөт хязгаарыг дэд төсөлд олгох гэх мэт.

Үндэсний хөгжлийн банк нь мөн бусад Үндэсний хөгжлийн банктай шууд харилцаа холбоог тогтоон бүс нутгийн хөгжлийг дэмждэг ба үүний жишээ нь Өмнөд Африкийн Үйлдвэрлэлийн хөгжлийн корпораци болон Лисоттогийн үндэсний хөгжлийн корпорациуд чадавхижуулах, техникийн туслалцаа, эдийн засгийн судалгаа, төслийн санхүүжилтийн чиглэлээр хамтран ажиллаж байна.

### **3.3. Үндэсний хөгжлийн банкуудыг чадавхижуулах**

Хөгжиж буй орнуудад 1990-ээд оны эхэн болон дунд үед дэд бүтцийн төслүүдэд хувийн хэвшлийн оролцоо их байсан. 1997 онд болсон Зүүн Азийн санхүүгийн хямралын үеэр дэд бүтцийн төслүүдэд их хэмжээний нуугдмал зардал гардаг нь тодорхой болсон. Энэ нь зарим талаар дэд бүтцийн салбарын дүрэм журмын асуудал хангалттай биш байдгаас шалтгаалсан. Зардлууд бодитой тусгагдаагүй, тендерийн болон худалдан авалтын бодлогууд хангалттай хэмжээнд боловсруулагдаагүй, тарифийн асуудал нарийвчлан судлагдаагүй, захиргааны байгууллага туршлагаар дутмаг байгаатай холбоотой.

Иймээс хөгжлийн банкуудыг чадавхижуулах буюу дүрэм журам, хяналтыг сайжруулах, менежмент, засаглалыг сайжруулах, үр дүнг хянах, хэмжих шаардлага гарч байна.

## **4. Улс орнуудын хөгжлийн банкуудын зорилго, үйл ажиллагаа**

### **4.1. Японы хөгжлийн банк**

Японы хөгжлийн банк нь 2008 оны 10-р сарын 1 нд Японы хөгжлийн банкны хуулийн дагуу хувь нийлүүлсэн корпораци хэлбэрээр Японы Засгийн газрын бодлогын санхүүжилтийн шинэчлэлийн нэг хэсэг болон байгуулагдсан.

- ✓ Хөрөнгө: 1,206,953 сая иен. Засгийн газрын эх үүсвэр
- ✓ Нийт актив: 16,247 тэрбум иен
- ✓ Зээл: 13,936 тэрбум иен
- ✓ Ажилчдын тоо: 1189, 10 салбар, 8 төлөөлөгчийн газар, гадаад дахь салбар 3, төлөөлөгчийн газар 1

Японы хөгжлийн банк нь Японы хөгжлийн банкны хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд уг хуулиар үр ашигтай байгууллагын засаглалын системийг бий болгож хяналт болон шийдвэр гаргалтын процессыг ил тод байлгадаг.

Бүтэц нь менежментийн болон гүйцэтгэх чиг үүргүүд бүхий нэгжүүдээс бүрддэг. Менежментийн чиг үүргийн хүрээнд ТУЗ нь банкны үндсэн бодлогыг тодорхойлж, үйл ажиллагаанд хяналт тавьдаг. Үйл ажиллагааны нэгж хэсэг тус бүрийн захирлуудаас бүрдсэн менежментийн хороо нь өдөр тутмын үйл ажиллагааг удирдан явуулдаг. Үйл ажиллагааны аудитын зөвлөл, шагнал урамшууллын зөвлөл, болон ТУЗ нь дотоод шалгалтын үүргийг хэрэгжүүлж, аудиторууд захирлуудын үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх явцыг хянадаг.

Японы хөгжлийн банкны хуулийн хүрээнд хэрэгжүүлдэг үйл ажиллагаа нь зээл болон баталгаа гаргах, хувьцааны хөрөнгө оруулалтыг урт хугацааны бизнесийн санхүүжилт шаардлагатай байгаа төсөл хөтөлбөрүүдэд олгох юм.

### **Засгийн газраас дараах үйл ажиллагаанд хяналт тавьж оролцдог.**

- Хямралын эсрэг хариу арга хэмжээг хэрэгжүүлэх, том хэмжээний бизнесүүдэд
- Олон улсын санхүүгийн хямарал эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бага байлгах үүднээс жижиг дунд үйлдвэрүүдэд зээлийг бодлогоор олгох,
- Засгийн газар нь Японы хөгжлийн банкны хувьцаандаа хяналт тавьж шаардлагатай арга хэмжээг авах эрхтэй. Урт хугацааны хөрөнгө оруулалт болон зээлийн эх үүсвэрийг найдвартай байлгах зорилготой ба байгууллагын урт хугацааны үнэ цэнэд хохирол учруулахаас сэргийлсэн арга хэмжээг авдаг.

## **Дунд хугацааны Засгийн газрын бодлогын зарчмууд**

1. Банк нь Засгийн газрын дунд хугацааны /3 жилийн/ бодлогын зарчмуудтай уялдуулан зээл бусад санхүүжилтийг олгоно.
2. Банк нь энэхүү дунд хугацааны бодлогын боловсруулалтанд санал өгч болно.
3. Энэхүү дунд хугацааны бодлогын зарчмуудад Банкнй үйл ажиллагаа нь Японы эдийн засаг нийгмийн бодлого болон бусад чухал асуудлуудад нөлөөлөх нөлөөллийг тусгана.
4. Энэхүү бодлогын зарчмуудыг боловсруулахад бусад хамааралтай байгууллагуудын удирдлагуудтай санал солилцоно
5. Энэхүү бодлогын зарчмуудад өөрчлөлт оруулах тохиолдолд дээрх санал авах, солилцох зарчмууд мөн үйлчилнэ.

## **Банкны дунд хугацааны менежментийн төлөвлөгөөнд дараах чиглэлүүд багтсан.**

1. Өсөлтийг дэмжих: Дэлхийн зах зээл дэх Японы өрсөлдөх чадварыг дэмжихийн тулд, Японы хөгжлийн банк санхүүжилтийн олон төрлийн цогц хэрэгсэл, тэр дундаа мезанин санхүүжилт, хөрөнгө оруулалт, зөвлөх үйлчилгээ болон бусад “мэдлэгт суурилсан бүтээгдэхүүнүүдийг” үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд тулгуурлан нэвтрүүлнэ.

Мөн Японы нийгмийн тогтвортой хөгжлийг хангах өсөлтийн салбарууд болох байгаль орчны бизнес, эрүүл мэнд, эмэгтэйчүүдэд чиглэсэн үйл ажиллагааг дэмжин ажиллана.

2. Дэд бүтэц, эрчим хүч: Японы дэд бүтцийн салбарт санхүүжилт хийж ирсэн туршлагатайгийн хувьд Японы хөгжлийн банк нь тээврийн сүлжээг сайжруулахад анхаарч ажиллана. PPP, PFI санхүүжилтийн хэлбэрүүдээр хуучин нийтийн тээврийн шинэчлэлийг хийнэ.

Японы зүүн хэсэгт болсон газар хөдлөлтөөс үүссэн эрчим хүчний асуудлыг шийдвэрлэхэд санхүүжилтийн олон төрлийн хэлбэрүүдийг санал болгож, төслийн хэрэгжилтэнд хамтран ажиллана.

3. Бүс нутгийн хэрэгцээнд зориулсан шинэчлэл: Японы хөгжлийн банкны үйлчлүүлэгчдийн бараг тал хувийг бүс нутгийн компаниуд эзэлдэг. Бүс нутгийн шинэчлэлийг тогтвортой, нөхцөл байдалд таарсан байдлаар хийхийн тулд Японы хөгжлийн банк бүс нутгийн үйлчлүүлэгчидтэй хамтран ажиллаж тэдний шинэ санаачлага, бизнесийг дэмжин ажиллана.
4. Аюулгүй байдлыг нэмэгдүүлэх: Японы хөгжлийн банк нь байгалийн болон санхүүгийн хямрал тулгарахад хариу арга хэмжээг үр дүнтэйгээр хурдан шуурхай авч ажиллана. Засгийн газраас чиглэл өгсөн, эсвэл бие даан хийж байгаа арга хэмжээний аль нь ч байсан мэдээлэл, судалгаа, шинжилгээн дээр үндэслэн хийгдэнэ. Хямралыг давах чадварыг нэмэгдүүлэхийн тулд Японы хөгжлийн банкнаас хямралд тэсвэртэй, бэлтгэлтэй байдлыг бий болгож бизнесийг хэвийн үргэлжлүүлэх чадварыг нэмэгдүүлэх зээлийн хөтөлбөрийг өргөжүүлнэ.

## **Хөрөнгө оруулалт болон санхүүжилтийн аргачлал**

1. Банк нь хөрөнгө оруулалт болон санхүүжилтийн аргачлалыг /жил бүрийн зээлийн болон бусад үйл ажиллагаа, зорилтот бизнес, Засгийн газрын бодлогыг тусгасан аргачлалыг боловсруулдаг/ дунд хугацааны Засгийн газрын бодлогын зарчмуудыг хэрэгжүүлэх хүрээнд гаргадаг.

2. Банк нь тухайн жилийн хөрөнгө оруулалт болон санхүүжилтийн аргачлалыг Сайдад урьдчилан танилцуулах ба батлагдсан аргачлалыг нийтлэнэ.
3. Аргачлалд өөрчлөлт орох тохиолдолд банк нь нэн даруй засварлагдсан хувилбарыг сайдад танилцуулах ба нийтлэнэ.

### **Бизнесийн үйл ажиллагааны хамрах хүрээ**

1. Корпораци нь өөрийн зорилгынхоо хүрээнд дараах бизнесийн үйл ажиллагааг эрхлэнэ:
  - 1.1. Хадгаламжийг зөвшөөрөх (хадгаламжийн гэрчилгээ болон бусад Засгийн газрын тогтоолоор баталгаажуулсан хадгаламжид хязгаарлалттай)
  - 1.2. Зээл олгох
  - 1.3. Хөрөнгийн дэмжлэг үзүүлэх
  - 1.4. Өрийн батлан даалт гаргах
  - 1.5. Үнэт цаас гаргах болон худалдан авах
  - 1.6. Үнэт цаас зээлдүүлэх
  - 1.7. Мөнгөний нэхэмжлэл эзэмших болон шилжүүлэх (Сангийн сайдын тушаалаар баталгаажсан шилжигдэн дамжигдаж болох банкны хадгаламжийн гэрчилгээ зэрэг орно)
  - 1.8. Тусгай зорилго бүхий компаниас гаргасан тусгай зориулалттай бонд болон давуу эрхтэй хөрөнгө оруулалтын үнэт цаасыг зөвшөөрөх
  - 1.9. Богино хугацааны өрийн бичиг эзэмших болон шилжүүлэх
  - 1.10. Банкны нэрийн өмнөөс зээл олгох гэрээг гүйцэтгэхэд байгууллага эсвэл зуучлагчийн үүрэгтэй оролцох
  - 1.11. Бусад аж ахуйн нэгж байгууллагуудад бизнесийн болон санхүүгийн шилжүүлгийн зөвлөх болон зуучлах үйлчилгээ үзүүлнэ
  - 1.12. Бусад аж ахуйн нэгж байгууллагуудад бизнесийн болон санхүүгийн менежментийн зөвлөх болон холбогдох мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлнэ
  - 1.13. Санхүүгийн болон эдийн засгийн асуудлаар судалгаа, сургалт явуулах
  - 1.14. Дээр дурьдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх
2. Корпораци нь дээрх үйл ажиллагааг зорилгынхоо хүрээнд хэрэгжүүлэхдээ Сангийн яамны удирдлагад захирагдана.
3. “Үнэт цаас” гэж Санхүүгийн хэрэгсэл ба валютын тухай хуульд заасантай ижил утга илэрхийлнэ
4. “Богино хугацааны өрийн бичиг” гэж холбогдох хуульд заасантай ижил утга илэрхийлнэ
5. Бизнесийн үйл ажиллагаа гэж Санхүүгийн хэрэгсэл ба валютын тухай хуульд заасантай ижил утга илэрхийлнэ
6. Тусгай зорилго бүхий компаниас гаргасан тусгай зориулалттай бонд болон давуу эрхтэй хөрөнгө оруулалтын үнэт цаас гэж холбогдох хуульд заасантай ижил утга илэрхийлнэ.

Монгол улсын хөгжлийн банкны хувьд Япон улсын хөгжлийн бодлогын банк болох Олон улсын хамтын ажиллагааны банктэй хамтран ажиллах, техникийн туслалцааг авах илүү боломжтой гэж үзэж байна.

#### **4.2. Хятадын хөгжлийн банк**

Хятадын хөгжлийн банк нь БХНАУ-ын Засгийн газрын сайдаар удирдуулдаг Улсын зөвлөлийн удирдлаган доор ажилладаг банк. 1994 онд Бодлогын банкны хуулиар үүсгэн байгуулагдсан ба Засгийн газрын эдийн засгийн хөгжлийн бодлогын хөдөлгөөр болж ажиллах чиг үүрэгтэй.

Хятадын хөгжлийн банк нь БНХАУ-ын бодлогын гурван банкны нэг бөгөөд томоохон дэд бүтцийн төслүүдэд шаардлагатай хөрөнгийг босгох үүрэгтэй банк юм. 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт активын хэмжээ 12.3 их наяд юаньд хүрсэн ба чанаргүй зээлийн хэмжээ 43 улирал дараалан 1-ээс бага хувьтай гарч байгаа үзүүлэлттэй, дэлхийн хамгийн том хөгжлийн санхүүжилтийн институци юм.

Хэрэгжүүлсэн томоохон төслүүдэд Шанхай Пудонгийн нисэх онгоцны буудал, Three gorges dam зэрэг орно. Банкнаас гаргасан үнэт цаас нь Засгийн газрын бондтой адил хэмжээнд авч үзэгддэг эрсдэлгүй хөрөнгө гэж тооцогддог ба гаргасан бондын хэмжээгээрээ Сангийн яамны дараа ордог.

Үндсэн салбар: дэд бүтэц, үйлдвэрлэл, эрчим хүч, тээвэр. Сүүлийн 10 жилд 1.6 их наяд юанийн хөрөнгө оруулалтыг дэд бүтэц, харилцаа холбоо, тээвэр, үйлдвэрлэлийн салбарт оруулсан.

Үр ашигтай санаачлага бүхий төлөвлөгөө нь хөгжлийн санхүүжилтийн гол цөм юм. Засгийн газрын төрөл бүрийн түвшний эдийн засаг болон нийгмийн хөгжлийн төлөвлөгөөнд идэвхитэй оролцон гаргаж, засгийн газрын болон байгууллагын үйлчлүүлэгчдэд өндөр түвшний системтэй санхүүгийн төлөвлөлт бүхий бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж, үндэсний эдийн засаг, нийгмийн хөгжилд шаардлагатай бүтээгдэхүүнийг тодорхойлон, бизнесийн загвар, замын зураглалыг гарган гадаад зах зээлд нэвтрэх стратеги болон байгууллагын хөгжлийн төлөвлөгөөний хамт боловсруулдаг. Энэхүү төлөвлөлт нь Хятадын хөгжлийн банкинд бизнесийн өсөлтийг хангаж эрсдлээс сэргийлэн хяналт тавих боломжийг бий болгодог.

Улсаас гаргасан стратегийн хуваарилалттай нийцүүлэн, Банк нь 2015 оноос 13-р Таван жилийн төлөвлөгөөний хугацаатай өөрийн бизнес төлөвлөгөөг уялдуулж байгаа ба урт хугацааны бизнесийн өсөлтийн зураглалыг гарган ажлын төлөвлөгөөг тодорхойлсон.

#### **4.3. Солонгосын хөгжлийн банк**

1954 онд Солонгосын хөгжлийн банкны хуулийн дагуу үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлэн үндэсний эдийн засгийг сайжруулах зорилгоор томоохон үйлдвэрлэлийн төслүүдийг санхүүжүүлэх үүрэгтэйгээр байгуулагдсан төрийн өмчит банк юм. Одоогоор тус банк Ази номхон далайн бүсийн санхүүгийн зах зээлийн номер нэг тоглогч, дотоодын хөрөнгийн зах зээлд тэргүүлэгч болоод байгаа ба санхүүгийн хэрэгцээг нь шийдвэрлэх замаар стратегийн үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, корпорацийн бүтцийг шинэчлэн үйл ажиллагааг хүндрэлээс гаргах, зөвлөх үйлчилгээ зэргийг үзүүлж байна.

#### **Үйл ажиллагааны чиглэл**

- Байгууллагын банкны үйлчилгээ –байгууллагын зээл, хөрөнгө оруулалт, баталгаа
- Хөрөнгө оруулалтын үйлчилгээ –M&A, хамтын хөрөнгө (venture capital), бондын андеррайтинг, төслийн санхүүжилт
- Олон улсын банк санхүүгийн үйлчилгээ –Синдикат, бүтцийн санхүүжилт, худалдаа, худалдааны санхүүжилт, NADFC(national agency of drug and control)
- Корпорацийн бүтцийн шинэчлэлт
- Зөвлөх үйлчилгээ

#### **4.4. Казахстаны хөгжлийн банк**

Банк нь хувь нийлүүлсэн компаи ба хувьцааны ихнэнх хэсэг нь үндсэний менежментийн холдингод харьяалагдана. Банк нь үндэсний хөгжлийн байгууллага юм.



Банкны үйл ажиллагаа нь Казахстаны үндсэн хууль болон банкны хууль, бусад хууль журмын дагуу явагдана.

Банкны хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэл, зээлийн хязгаарлалт, чиглэл, нөхцөл, зээл олгох явц, хувьцааны хөрөнгийн байршуулалт, хамтарсан санхүүжилт, баталгаа гаргалт нь Банкны зээлийн бодлогын санамж бичигт заасан ба үндэсний менежментийн холдингоор зөвшөөрөгдсөн.

Банкны үйл ажиллагааны зорилго нь Улсын хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг сайжруулах, дэд бүтэц болон үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлэх, дотоодын болон гадаадын хөрөнгө оруулагчдыг үндэсний эдийн засаг руу татах юм.

- Хөрөнгө оруулалтын төслийн чиглэл нь шинэ болон одоо байгаа үйлдвэрүүдийн өргөжүүлэлт, шинэчлэлтийн зорилготой, дунд болон урт хугацаатай байна.
- Экспортын үйл ажиллагааны санхүүжилт нь экспортыг идэвхжүүлэх зорилгоор Казахстан улсын иргэний хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа буюу Казахстанд үйлдвэрлэж экспортод гаргадаг бүтээгдэхүүн байна
- Хувьцаанд хөрвөх subordinated зээл
- Улсын эдийн засгийн санхүүжилтийг идэвхжүүлэх-бусад санхүүгийн байгууллагын зээлд баталгаа гаргах, хамтран санхүүжилт хийх гэх мэт
- Засгийн газраас хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төслийн механизмыг сайжруулах үйл ажиллагаа
- Бусад хуулийн хүрээний үйл ажиллагаа

Дараах чиг үүргүүдийг хэрэгжүүлнэ:

- Санхүүжүүлэх, хамтран санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төслүүд болон экспортын үйл ажиллагааг сонгох
- Үндэсний болон бүс нутгийн хэмжээний эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүжилтийн төслүүдэд агентийн үүргээр оролцох, мөн улсаас баталгаа гаргасан зээл
- Үндэсний болон бүсийн хөрөнгө оруулалтын төслийн шинжилгээг хийх
- Үндэсний болон бүс нутгийн хэмжээний төслүүдийн хэрэгжилтэнд хяналт тавих

Банкны эрх:

- Санамж бичгийн хүрээнд зээлийн бодлогыг тодорхойлох
- экспорт болох зээлийн үйл ажиллагааг шалгалтын үндсэн дээр зохистой байдлаар удирдах
- Банкны шинжилгээнд мэргэжилтнүүд, зөвлөхүүдийг татан оролцуулах
- Зээл татах
- Хөрөнгө оруулалтын төслийг сонгох
- Өөрийн бие даасан баталгаа гаргах, нийт хэмжээг санамж бичигт заасанд багтаана

#### **4.5. Африкийн хөгжлийн банк**

##### **Зорилт**

Банкны 10 жилийн стратегийн төлөвлөгөө нь Африкийн орнуудыг хөгжлийн дараах хоёр үндсэн чиглэлээр хөгжүүлэхэд чиглэж байна.

##### **1. Хүртээмжтэй өсөлт**

Хамгийн эхний, суурь зорилт нь илүү хүртээмжтэй өсөлтийг бий болгох, ингэснээр зөвхөн иргэдэд тэгш үйлчилгээ хүртэх боломжийг олгох, улмаар ажлын байрыг олноор нэмэгдүүлж, ядуурлыг бууруулах юм.

Банк нь дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийх замаар хувийн секторын нөөц бололцоог дээшлүүлж, хүйсийн тэгш байдал, нийтийн оролцоог сайжруулна. Хүн амын боловсрол, нийгмийн дэд бүтцэд анхаарснаар өрсөлдөх чадварыг сайжруулахаас гадна дотоодын хөдөлмөрийн зах зээлийн шаардлагуудыг хангахад дөхөм болно.

## 2. Ногоон өсөлт

Хоёрдахь зорилт нь дээрх хүртээмжтэй өсөлт нь тогтвортой байх нөхцлийг хангах буюу Африкийн бүс нутгийн байгаль орчныг хамгаалах, ундны усыг сайжруулах, эрчим хүчний хүрэлцээ, хүнсний аюулгүй байдлыг хангах, байгалийн баялгийн тогтвортой хөгжлийн зарчмаар хэрэгэлэх хэрэгэлээг бий болгох, шинэ технологийг дэмжих, ажлын байрыг бий болгох, эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэнэ.

Банк нь байгалийн баялгийг зохистойгоор ашиглах, байгаль орчин, нийгэм эдийн засгийн эрсдлийг зохистойгоор удирдах замаар ногоон хөгжлийг дэмжих юм.

### Алсын хараа

Тогтвортой эдийн засгийн өсөлтийн хөдөлгүүр болж ядуурлыг бууруулахад чухал нөлөө үзүүлэхэд гол нөлөө үзүүлэгч Өрсөлдөх чадвартай хувийн секторыг дараагийн 10 жилд болон түүнээс цааш хугацаанд бий болгоно.

### Зорилго

Өргөн суурьтай эдийн засгийн өсөлтийг дэмжиж, үр ашигтай хувийн секторын оролцоог хөгжүүлэн тогтвортой хөгжлийг хангаж, ядуурлыг бууруулах.

### Хүснэгт 1. Африкийн хөгжлийн банкны үйл ажиллагаа

<b>Хүлээгдэж буй үр дүн</b>	Хөрөнгө оруулалтыг дэмжин, нийгмийн хариуцлагатай үйлдвэрлэлийг хөгжүүлэн бизнесийн орчинг бий болгох	Нийгэм эдийн засгийн дэд бүтцийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэх	Олон талт, хөдөлгөөнт, шинийг санаачлагч, өргөн суурьтай үйлдвэрлэгчид, дотоодын болон экспортын хэрэглээнд зориулж бүтээгдэхүүн үйлчилгээг үйлдвэрлэх
<b>Хувийн секторын хөгжлийн боломжийг нэмэгдүүлэн бүс нутгийн гишүүн орнуудыг дэмжиж илүү оролцоотой, байгаль орчны хувьд тогтвортой эдийн засгийн хөгжилд хүрэх, нийгмийн болон эдийн засгийн дэд бүтцийн хүрэлцээг сайжруулах, бүс нутгийн хүрээнд хувийн секторын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх</b>			
<b>Үндсэн үйл ажиллагаа</b>	Хувийн секторын хөгжүүлэхэд чиглэсэн бодлого, хууль эрхзүйн орчин (зөөлөх дэд бүтэц) бий болгох	Бүсийн гишүүн орнуудын хувийн секторын хөгжилд нөлөөлдөг дэд бүтцийн асуудлуудыг (ялангуяа тээвэр, эрчим хүч) тодорхойлоход туслалцаа үзүүлэх. Ур чадвар сайжруулах, боловсролд чиглэсэн үйл ажиллагаа сонгон явуулах	Бүсийн гишүүн орнуудын хувийн секторын хөгжилд нөлөөлдөг үйлдвэрлэлийн түвшний бэрхшээлүүдийг тодорхойлоход туслалцаа үзүүлэх. Үүнд ур чадварын дутагдал, санхүүжилт авахад тулгардаг бэрхшээл,
<b>Гол арга хэрэгслүүд</b>	-хөтөлбөрт суурилсан үйл ажиллагаа -техникийн туслалцаа, чадавхижуулах хөтөлбөр -эдийн засгийн болон салбарын ажлууд -төслийн зээл, баталгаа -бодлогын хэлэлцүүлэг болон зөвлөх үйлчилгээ -донор орнуудтай харилцах харилцаа	-төслийн зээл, баталгаа -техникийн туслалцаа, чадавхижуулах хөтөлбөр -эдийн засгийн болон салбарын ажлууд -бодлогын хэлэлцүүлэг болон зөвлөх үйлчилгээ -донор орнуудтай харилцах харилцаа	-шууд санхүүжилтийн туслалцаа: урт хугацааны зээл, хувьцаа, баталгаа, синдикат зээл, андеррайтинг -зөвлөх үйлчилгээ -техникийн туслалцаа, чадавхижуулах хөтөлбөр

#### **4.6. ХБНГУ-ын KfW Хөгжлийн Банк**

##### **Бодлого**

KfW Хөгжлийн Банк нь өөрийн зорилтын хүрээнд хөгжлийн бодлогод хүрэхийн тулд Германы Холбооны Засгийн газарт туслахын зэрэгцээ олон улсын хөгжлийн бодлогод 50 гаруй жил тусалж ирсэн.

##### **Үйл ажиллагааны чиглэл**

KfW Хөгжлийн Банк нь Германы Холбооны Засгийн газар болон Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны(BMZ) нэрийн өмнөөс ихэвчлэн хөгжиж буй орнуудын хувийн хэвшлийн салбарт төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх болон дэмжих үйл ажиллагааг явуулдаг.

Банкны зорилт нь өөрийн түнш орнуудын ядууралтай тэмцэхэд туслах, энх тайвныг хамгаалах, байгал орчин болон уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх, зохих чиглэлд даяаршлыг хадгалахад оршино.

##### **Үндсэн зорилтууд**

KfW Хөгжлийн Банк нь түнш орнуудад төрөл бүрийн тоног төхөөрөмжийг хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр нийлүүлэхээр үүрэг амлалтыг авсан. Санхүүжилтын загвар нь тухайн орны өрийн хэмжээ, эдийн засгийн үр дүн, хөгжлийн төвшин, төслийн хүчин чадлын гүйцэтгэл болон төслийн төрлөөс хамаарахаар тодорхойлсон. Санхүүжилтын загвар нь төсвийн сангаас цэвэр тусламж болон зээлээс бүрдэхээр заасан. Гэхдээ KfW Хөгжлийн Банк нь буцалтгүй тусламж болон зээлийг хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр зөвхөн өөрийн эх үүсвэрээс санхүүжүүлэхээр заасан байдаг.

Германы Санхүүгийн хамтын ажиллагааны хүрээнд Буцалтгүй тусламж нь Германы Холбооны засгийн газрын төсвөөс ядуу болон нэн ядуу орнуудад зарцуулагддаг. Санхүүжилт эргэн төлөгдөхгүй. Гэсэн хэдий ч санхүүжилтийг авахын тулд Хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлт нь түнш орнуудын өмчлөл, хүлээсэн үүрэг амлалтуудтай заавал тохирч байх ёстой. Гэхдээ ихэвчлэн энэхүү буцалтгүй тусламж болон маш бага хүүтэй стандарт зээлийг ядуу болон нэн ядуу орнуудад олгодог.

Хөгжлийн зээлийн тохиолдолд KfW Хөгжлийн Банк нь Германы Холбооны засгийн газрын төсөв болон хөрөнгийн захаас маш тааламжтай нөхцөлтэйгээр өөрийн эх үүсвэрийг босгодог. KfW Хөгжлийн Банкны өөрийн эх үүсвэрийг түнш орнуудад олгосноор дахин хямд санхүүжилтын сонголтоос ашгийг AAA зэрэглэл болон Холбооны Засгийн газраас үзүүлж буй хэсэгчилсэн эрсдэлийг тараан байршуулах зарчмаар хүртдэг. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яам (BMZ)-тай хамтын ажиллагааны хүрээнд төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх хэмжээг нэмэгдүүлэхээр Хөгжлийн зээлийг түнш орнуудад олгохоор болсон. The terms and conditions ply with the international agreements for Official Development Assistance (ODA).

Урамшууллын зээл нь хөгжиж буй орнууд дахь түншүүдэд хөрөнгийн зах дээр KfW-р 100 хувь босгосон Засгийн газраас захиалсан зээл байна. Энэхүү зээл нь хөгжлийн бодлогод нийцсэн төсөлд зориулагдах бөгөөд өөрөөр хэлбэл, Санхүүгийн хамтын ажиллагааны урамшууллын зээл нь Санхүүгийн хамтын ажиллагааны хөгжлийн зээл, арилжааны банкны зээл хоорондын орон зайг дүүргэхэд чиглэгдэнэ. Урамшууллын зээлийг олгох болсноор KfW нь төсвийн саад тотгоргүйгээр хөгжлийн илүү их төслийг санхүүжүүлэх боломжтой.

Монгол улсын хөгжлийн банкны хувьд Германы Холбооны Засгийн газрын Хөгжлийн бодлогын банк KfW болох Германы хөгжлийн банктэй хамтран ажиллах, техникийн тусалцааг авах ажиллагааг өргөтгөх.

#### **4.7. Польшийн Хөгжлийн Банк (BGK)**

##### **Бодлого**

Польшийн Хөгжлийн Банк (BGK) нь Польшийн цорны ганц төрийн өмчийн банк бөгөөд 1924 онд байгуулагдсан. Банкны үндсэн үйл ажиллагаа нь экспорт, импортын үйл ажиллагааг дэмжих, дэд гэрээг байгуулах, дэд гэрээлэгч болох, Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг дэмжих юм.

##### **Үйл ажиллагааны чиглэл**

Польшийн Хөгжлийн Банк (BGK)-ны тэргүүн чиглэл нь олон нийтийн санхүүгийн салбарт банкны үйлчилгээг үзүүлэх, санхүүжилтийг зохион байгуулах, экспортыг дэмжих тогтолцоог бүрдүүлэхэд зорьж ажилладаг.

BGK нь өөрийн санхүүжилтийн сангаас Польш улсын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах зорилго бүхий гадаадын худалдан авагчдад зээлийг олгодог. Үйлчилгээг дэмжих төрөл : Зээлийн баталгааны схем, бага хүүтэй зээл.

### **Үндсэн зорилтууд**

Жижиг Дунд Үйлдвэрийг Европын холбооны орнуудтай хамтран болон тэдгээрийн нутаг дэвсгэр дээр байгуулах /бизнесийн аливаа хэлбэрээр/ зорилтыг тавьдаг. ЕХ-ны орнуудаас гадна чөлөөт зах зээлийн зарчимд тулгуурлан Australia, Argentina, Brazil, Canada, Chile, Colombia, Mexico, USA, Venezuela, China, Indonesia, India, Israel, Japan, Malaysia, Norway, Russia, Saudi Arabia, Singapore, South Korea, Switzerland, Taiwan, Thailand, Turkey, UE Emirates, Ukraine, Vietnam, Algeria, Angola, Egypt, Morocco, Nigeria, Tunisia, South Africa зэрэг орнуудтай эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлдэг.

Польш улс нь эдийн засгийн хамтын ажиллагааг Европын Комиссын Дотоод зах зээл, Үйлдвэр, Шинэ Бизнес, ЖДҮ болон тэдгээрийн санхүүжилтийг хариуцсан Ерөнхий газартай хамтран ажиллахыг хүссэн аливаа компани, байгууллагуудтай хамтран ажиллахыг эрхэмлэдэг.

Польш улсын Хөгжлийн банкны хувьд Европын комиссоос баримтлаж буй нэгдсэн бодлогын хүрээнд гишүүн орнуудын нэгэн адил санхүүгийн гарцыг сайжруулах, санхүүгийн салбарт үзүүлж буй бүтээгдэхүүн, үйлчилгээнээс хувь хүртэх өргөн боломжтой юм. Ялангуяа, Зээл болон зээлийн баталгаа, хувийн өөрийн хөрөнгө оруулалтын төрөл (venture capital), хөрөнгийн зах зээлийн оролцоо, олон нийтээс хөрөнгө босгох (crowdfunding) зэрэг санаачилгуудыг дэмжин ажилладаг.

Энэхүү санхүүгийн дэмжлэгийн хүрээнд, тухайлбал, 1998 оноос ЕХ нь ЖДҮ эрхлэгчдэд зориулж тусгайлан Competitiveness and Innovation Framework Programme (CIP) хөтөлбөрийг хэрэгжүүлснээр зээлийн баталгааг өөрийн хөрөнгө, барьцаа хөрөнгө байхгүй ЖДҮЭрхлэгчдэд үзүүлж, эрсдлийг санхүүгийн байгууллагуудаар хуваалцах зарчмаар санхүүжилтийн хэмжээг амжилттай хэрэгжүүлж чадсан.

Польшийн Хөгжлийн Банк (BGK) нь ЕХ-ны гишүүн орны хувьд ЕХ-ны санхүүгийн нэгдсэн бодлогоор дэмжигдэж явагддаг хэдий ч үйл ажиллагааны хувьд Монгол улсын хөгжлийн банктэй илүү ижил төстэй үйл ажиллагааг явуулдаг байна. Иймд Польшийн туршлагаас судлан ажиллах. Нэн ялангуяа өөрийн хөрөнгө оруулалтын(equity participation) санхүүгийн хэрэгслийг санхүүжилтийн хэмжээг нэмэгдүүлэхэд илүү их хэрэглэж байна.

## **III. Хөгжлийн банк оршин тогтнох үндэс**

Улс орны эдийн засгийн зарим салбарт зах зээлийн эдийн засгийн зарчим хүрч үйлчилж чадахгүй байсаны улмаас улс орнуудыг санхүүгийн системд хөгжлийн банкуудаар дамжуулж оролцох гол үндэс болсон. Гэсэн хэдий ч 1980-аад оны сүүлч болон 1990-ээд оны үед хөгжиж буй орнуудад хувийн санхүүгийн салбар эрчимтэй хөгжсөн нь улсын банкуудыг олноор нь татан буулгах болон хувьчлахад хүргэж, мөн хөгжлийн банкуудын үйл ажиллагааны үр дүнд эргэлзэх байдал шинээр үүсч тэдэнд санхүүгийн боломж олгохыг хязгаарлаж эхэлсэн. Эдгээр өөрчлөлтийг даган олон хөгжлийн банкууд үйл ажиллагааныхаа чиглэлийг өөрчилж хувийн секторын хүрч ажиллаж чадахгүй байгаа салбаруудад чиглүүлэх болсон. Зах зээлийн түр зуурын уналтаас үүдсэн 2000 оны эхэн үеийн санхүүгийн эхний хямрал нь зарим улс орнуудын засгийн газруудыг санхүүгийн системийн гажуудал болон зээлийн хямралын эсрэг идэвхтэй үйл ажиллагаа явуулахад хүргэсэн. Зээлийн хямралаар илэрч буй эдийн засгийн мөчлөгийн эсрэг төрийн оролцоо нь янз бүрийн хэлбэрээр илэрч байлаа.

Ихэнхи төв банкуудын эрх үүрэг зөвхөн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, тухайн валютыг тогтвортой барьж байхаар хязгаарлагдаж байсан тул зарим улс орнууд үйл ажиллагаа явуулж буй

бусад санхүүгийн байгууллагуудыг, тухайлбал, үр өгөөж өндөртэй салбаруудыг санхүүжүүлэх зорилготой Хөгжлийн банкуудыг ашиглаж байсан. Улс орнууд энэ зорилгодоо үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулж буй санхүүгийн байгууллагуудыг илүүд үзэж байлаа. Учир нь үйл ажиллагаа нь тогтсон, өөрийн үйл ажиллагаа явуулж буй салбараа сайн мэддэг болон зээл олгох ноу хаутай ийм төрлийн байгууллагууд болох Хөгжлийн банкууд нь богино хугацаанд Засгийн газрынхаа үйл ажиллагааг урагшлуулж чадна гэж үздэг. Эдгээр байгууллагууд нь түр хугацааны эдийн засгийн хямралын мөчлөгийг үр дүнтэй арга хэрэгслээр сааруулах зорилготой тул эдийн засгийн хямралыг сааруулж, санхүүгийн салбарыг сэргээсний дараа эдгээр байгууллагын үйл ажиллагаа, оролцоог хумих механизмыг бий болгох нь чухал гэж үздэг.

Хөгжлийн банкууд нь тухайн улс оронд урт хугацааны хөгжлийг бий болгох болон эдийн засгийн мөчлөгийн эсрэг ажиллах үүрэг оролцоотой байдаг. Зах зээлийн эдийн засагтай улс орнуудын хөгжлийн банкуудад санал болгож буй хэтийн зорилго нь хагас арилжааны журмаар ажиллаж нээлттэй зах зээлийн эдийн засагт урт хугацааны бүтцийн, богино хугацааны мөчлөг бүхий зайг нөхөж ажилладаг Засгийн газрын бодлогыг үр өгөөжтэй хэрэгжүүлэх хэрэгсэл байх нь илүү зохистой гэж үзжээ. Зарим орнуудад Хөгжлийн банк нь 1980-90-ээд оны хувьчлалын давалгаанаас үлдсэн цорын ганц төрийн санхүүгийн байгууллага болж байгаа юм. Түүнчлэн урт хугацаанд бүтцийн хувьд зай нөхдөг үзэл санаа нь Хөгжлийн банкыг байлгах шалтгаан болдог бол төрийн арилжааны банкууд санхүүгийн бүх төрлийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй хэдий ч тэдний оршин байгааг зөвтгөх шалтгаан нэн ховор байдаг.

Хөгжлийн банк нь хувийн хөрөнгө оруулагчдын санхүүжүүлэх сонирхолгүй нийгмийн ач холбогдол өндөртэй төслүүдэд урт хугацаатай хөрөнгө оруулалтуудыг хийх чиглэлээр ажилладаг. Мөн санхүүгийн боломж хомс хөдөө аж ахуй, барилга орон сууц зэрэг салбаруудад санхүүжилт хийдэг.

Бодлого боловсруулагчид улс орны эдийн засгийн хөгжил, бодлогын зорилтуудыг хэрэгжүүлэхдээ тухайн орны онцлог, түүх соёлыг бодолцож Хөгжлийн банкиг хамгийн үр дүнтэйгээр ашиглахаа тодорхойлох ёстой. Зах зээлд шууд оролцох уу, эсхүл шууд бусаар хоёр дахь үеийн банк болж ажиллах уу, эсхүл хувийн сектортой өрсөлдөх үү болих уу, үйл ажиллагааны зардлаа бүрэн нөхөх үү, улсаас татаас авч явах уу зэрэг асуудлыг сайтар судалж зохих дүгнэлтийг гаргасан байх шаардлагатай.

#### **IV. Засгийн газар, Хөгжлийн банкны харилцаа**

Ихэнхдээ улс төрийн оролцоо, муу засаглал, заримдаа авилгал нь Хөгжлийн банкны санхүүгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, Хөгжлийн банк татан буугдах болон Хөгжлийн банкны өр төлбөрт гаргасан засгийн газрын баталгаанаас үүдэлтэй санхүүгийн чухал зарлага гарахад нөлөөлдөг байна.

Засгийн газрын ач холбогдол бүхий ажлыг хэрэгжүүлэх зорилгоор олон улс орны засгийн газрууд төрийн мэдлийн санхүүгийн байгууллагууддаа засгийн газрын мөрийн хөтөлбөрт заасан төслүүдийг санхүүжүүлэх үүргийг өгч байсан ба ингэхдээ эдгээр төслүүдийн хувьд болон нийгэмд үзүүлэх өгөөжийг хайхардаггүй байсан бөгөөд эдгээр төслүүдтэй холбоотойгоор гарч болох алдагдлын улмаас банкинд учрах үр дагаврыг тооцдоггүй байжээ.

Энэхүү шалтгаануудын улмаас Хөгжлийн банкны үүрэг болон шаардлагын тухай үзэл бодол ХХ дугаар зуунд бүрэлдэн тогтсон байна. 1950-аад оны үед хөгжлийн банк байгуулах нь илүү ашиггүй

байдал болон гажуудал үүсгэдэг хэмээн үздэг байсны дараагаар энэхүү үзэл нь хөгжлийн агентлагууд хэмээх илүү ерөнхий үүрэг бүхий байгууллага уруу шилжиж зах зээлийн эерэг оролцоотой илүү олон үзлээс бүрдсэн гэсэн үзэл бодол болж, бүр зарим тохиолдолд санхүүжилт бус сурталчилгаанд зориулагдсан хэмээн үзэж байлаа. 1980-аад оны сүүл болон 1990-ээд оны эхээр хөгжиж буй олон улс оронд хувьчлал болон өр барагдуулалт эрчимтэйгээр явагдаж, Хөгжлийн банкны үйл ажиллагаа болон хэлбэлзэл ихтэй санхүүгийн салбар дахь хувийн хэвшлийн хөгжилтэй харьцуулан Хөгжлийн банкны оршин тогтнох үндэслэл зэрэг асуудлыг тусгаж улмаар Хөгжлийн банкуудад байгаа эх үүсвэрт хязгаарлалт тавьсан. Түүнчлэн тус байгууллагын хөгжих чадварыг хангахын тулд Хөгжлийн банкуудад шинэчлэлт хийгдэж, тэдний засаглалыг бэхжүүлсэн. Дээр өгүүлсэн ихэнх арга хэмжээг хэрэгжүүлж Хөгжлийн банкны шинэчлэлийг амжилттайгаар нэвтрүүлсэн улс бол Мексик юм.


Засгийн газрын дэмжлэгтэй төслүүдийг санхүүжүүлэхээр Хөгжлийн банкнаас гаргах зээл олгох шийдвэрт Засгийн газар оролцох юм бол эх үүсвэрийг оновчтой хуваарилах зорилт үгүй болж улмаар засгийн газрын төсвийг ашиглах илүү нуугдмал механизм болон өөрчлөгддөг байна.

Монгол улсын хөгжлийн банкыг байгуулах үйл явцтай төстэй жишээг татсан Хөгжлийн банкуудын үйл ажиллагааг харьцуулан судалсан нэрт эдийн засагч Эва Гутиеррез, Хайнз П. Рудолф нарын судалгаанаас авч үзье.

Зээл авах хязгаарлагдмал хүчин чадалтай Засгийн газар дэд бүтцийг хөгжүүлэхээр боллоо гэж үзье. Эдгээр төслүүдийг санхүүжүүлэх сонирхол санхүүгийн салбарт байхгүй тохиолдолд үүнийг санхүүжүүлэх хамгийн тодорхой арга нь засгийн газрын төсөв болдог байна. Ардчилсан улс орнуудад үүнийг Парламент нь баталдаг. Төсөв хязгаартай байдаг тул засгийн газраас дэд бүтцийн төслүүдийг төсвөөс санхүүжүүлэх боломж багасдаг, тиймээс уг асуудлын шийдэхийн тулд засгийн газрууд Сангийн сайдаа ТУЗ-ийн даргаар томилж Засгийн газраараа удирдуулсан Хөгжлийн банкыг байгуулж болох юм.

Засгийн газар дэд бүтцийн төслүүдийг төсвөөс санхүүжүүлэхийн оронд төсвийн мөнгийг шинээр байгуулагдсан Хөгжлийн банк уруу эхний хөрөнгө болгон оруулдаг. Нэгэнт Хөгжлийн банкууд тухайн хөрөнгийг зарцуулах эрхтэй болох тул Хөгжлийн банкыг байгуулах нь засгийн газарт дэд бүтцийг санхүүжүүлэхэд хэдэн дахин хөрөнгө оруулалт хийхтэй тэнцсэн (гурав дахин гэж үзвэл) хөрөнгө босгох боломжийг олгоно. Тус хөрөнгийг төрийн сан (өөрийн хөрөнгө) болон банк хоорондын зах зээлийн эх үүсвэрээр санхүүжүүлдэг. Улмаар Хөгжлийн банкинд засгийн газрын баталгаатай Өр гаргах эсхүл өөрийн зээл олгох чадавхиа нэмэгдүүлэхээр төрийн сангийн нөөцөөс авах зөвшөөрлийг олгоно. Эцэст нь засгийн газар Хөгжлийн банкны багцад байгаа төслүүд хангалттай бэлэн мөнгөний урсгал бий болгохгүй байгааг ойлгодог. Хэд хэдэн удааг хөрөнгө оруулалт хийсний дараагаар засгийн газар Хөгжлийн банкыг зайлшгүй хаах шаардлагатай болдог бөгөөд зээл олгогчдод тэдний зээлдүүлсэн хөрөнгөөс хэд дахин илүү хэмжээний (жишээ нь арав дахин буюу түүнээс их байж болно) хөрөнгийг буцаан төлдөг. Өнгөрсөн хэдэн арван жилд хөгжиж байгаа улсууд төрийн санхүүгийн байгууллагуудаа хувьчилсан нь тухайн байгууллагууд ажлаа муу хийсэнтэй холбоотой ба үүнийг тогтвортой бус буцаан төлөх чадваргүй болсон зээлүүд болон алдагдлаа нөхөхийн тулд үргэлжлүүлэн хөрөнгөжүүлж байснаар тодорхойлно.

Зураг 3. Хөгжлийн банк Засгийн газрын харилцаа



## V. Хөгжлийн банкны эдийн засгийн үүрэг

Хөгжлийн банк нь эдийн засгийн хөгжлийг дэмжих бодлогын хэрэгсэл болж байдгаараа онцлогтой. Хөгжлийн банкны үүрэг нь олон төрлийн эх үүсвэрээс үүдэлтэй зах зээлийн уналтыг бууруулахад оршино. Үүнд:

1. Зээл анх удаа авах гэж буй зээлдэгч нар санхүүжилтанд хамрагдахад саад болдог үнэ өртөг ихтэй олон янзын мэдээллийн бүрдүүлэлт,
2. Нийгмийн ач холбогдол бүхий төслийн санхүүжилтыг хангалтгүй олгох (санхүүгийн ашиг нь уг төслийн нийт үнэ цэнийг илэрхийлж чадахгүй)-д хүргэдэг гадаад хүчин зүйлүүд орно.

Хөгжлийн эхэн үеийн шатандаа явж байгаа хууль эрх зүйн хувьд сул тогтолцоотой улс орнууд төрийн санхүүгийн байгууллагуудтай байх үндэс нь засаг төртэй хамтран ажиллахын давуу тал гэж мөн тайлбарладаг.



Зураг 4. Хөгжлийн банкны эдийн засгийн үүрэг



## 1. Хөгжлийн банкны эдийн засагт үзүүлэх нөлөөний давуу ба сул тал

Зах зээлийн уналт нь Хөгжлийн банкыг оршин тогтох учир шалтгаан болдог ч банкны салбарт төрийн зүгээс оролцох нь мөн эрсдлийг дагуулдаг. Өөрийн давуу талаа шударга бусаар ашиглан хувийн хэвшлийнхэнтэй шууд өрсөлддөг төрийн өмчит байгууллагууд нь бусад гажуудлыг үүсгэж, хувийн салбарын үйл ажиллагаанд саад болдог. Зарим улсын засгийн газрууд Хөгжлийн банкны үүрэг бол хувийн хэвшилтэй өрсөлдөөн бий болгох замаар зээлдэгчдийн эрх ашигт нийцүүлэн хүүгийн хувийг бууруулж улмаар эдийн засагт шинээр хөрөнгө оруулалт хийх нөхцлийг бүрдүүлнэ гэж ойлгодог.

Үнэн хэрэгтээ засгийн газар, жишээлбэл бага хүү санал болгох зэргээр хувийн салбартай шууд өрсөлдвөл төлбөрийн чадвартай харилцагчид арилжааны банкнаас Хөгжлийн банк уруу шилжих магадлалтай. Ингэвэл арилжааны банкууд засгийн газраас явуулж буй шударга бус өрсөлдөөнтэй тулгарч байна гэж үзэн улмаар зах зээлд өрсөлдөхүйц санхүүгийн шийдлүүдийг санал болгоход хөрөнгө оруулалт хийхээ болих хандлагатай болно. Цаг хугацаа өнгөрөх тусам хувийн салбартай хийж буй засгийн газрын өрсөлдөөн нь арилжааны банкуудын харилцагчдын тоог эрс багасгаж зах зээлд гажуудал үүсгэдэг ба энэ нь зах зээлд шинэ хөрөнгө оруулалт хийх нөхцлийг заавал ч бий болгодоггүй байна.

### **Хөгжлийн банкны эдийн засгийн нөлөөний судалгаа:**

Дэлхий дээр Хөгжлийн банктэй холбоотой өчнөөн туршлагууд байдаг бөгөөд өнгөрсөн 10 жилийн туршид тэдгээрийн үзүүлсэн нөлөөг хэмжихээр олон удаа оролдсон боловч нэгдсэн үр дүнд хүрч хараахан чадаагүй байна.

1. 2002 онд Ла Порто зэрэг эрдэмтдийн судалгаа нь төрийн өмчит банкуудтай байх нь эдийн засгийн болон санхүүгийн хөгжилд хувь нэмэр оруулсан гэх үндэслэлийг гаргаж чадаагүй.



2. 2004 онд Леви болон бусад судлаачид Ла Портагийн судалгааг дахин үзэж үр дүнгүүд нь хүчтэй бус байна хэмээжээ.
3. 2010 онд Корнер болон Шнебл нар санхүүгийн хөгжлийн хувьд хөгжил дорой бөгөөд институционал чанарын хувьд доод түвшинд байдаг гол төлөв хөгжиж байгаа улс орнуудад л Хөгжлийн банкны зах зээлд эзлэх өндөр хувь нь хөгжилд сөрөг нөлөөлөл үзүүлдэг болохыг тогтоосон байна.
4. 2013 онд Андрианова зэрэг судлаачид банкны салбар дахь төрийн өмчлөл их байх нь түргэн өсөлттэй холбоотойг тогтоожээ.

Зах зээлийн уналт нь дангаараа Хөгжлийн банк оршин тогтнох үндэс болдоггүй. Санхүүгийн зах зээлд мэдээллийн тэнцвэргүй байдалтай холбоотой асуудал ихээр гардаг ч төрийн салбарт үйл ажиллагаа явуулахын тулд уг салбар нь хувийн хэвшилтэй харьцуулбал илүү мэдээлэлтэй байх ёстойг шаарддаг бөгөөд энэ мэдээллээ хуваалцдаггүй байна. Бодлого боловсруулагчид үүнээс зардал багатай, цаг хугацаа хэмнэсэн зах зээлийн уналтыг шийдвэрлэх интервенцийн өөр төрлийн арга хэмжээ байгаа эсэхийг тодорхойлох шаардлагатай болдог аж. Жишээлбэл, зээлийн түүхтэй байх болон хөрөнгө барьцаалалтыг сайжруулахад чиглэгдсэн шинэчлэлүүд нь Хөгжлийн банкнаас шууд зээл олгохоос илүүтэйгээр санхүүжилт хүртэхэд туслалцаа үзүүлэх илүү үр дүнтэй төрийн интервенц байх юм.

Гадаад нөхцөл байдлаас үүдэлтэй зах зээлийн уналтыг төсвийн татаасаар шийдвэрлэх нь харьцангуй давуу шийдэл юм. Гэвч зарим нийгэмд бодлогын давуу эрхийг харуулсан хөнгөлөлт үзүүлснээс зээл олгож, зээлийн эргэн төлөлтийг бий болгохыг илүүтэйгээр үнэлдэг.

## **2. Эдийн засгийн мөчлөг дэх Хөгжлийн банкууд**

Эдийн засгийн судалгаануудад Хөгжлийн банкуудын үйл ажиллагаа нь эдийн засгийн мөчлөг/циклийг сөрөх загвараар зээл олголтыг явуулсанаараа зээлийн зах зээл дэх төрийн оролцоог нэмэгдүүлж байдаг бөгөөд зарим эдийн засагчид иймэрхүү төрийн оролцоог зөвтгөсөн байдаг.

Эдийн засагч Левай нарын судалгаанд; Эдийн засгийн хямралын үеэр хувийн банкууд зээл олгох болон бага хүүтэйгээр зээлдүүлэх сонирхол багатай байдаг. Тэд зээл олголтоо нэмэгдүүлснээрээ эдийн засгийг хямралаас гарахад тус болохыг тооцдоггүй. Энэхүү зохицуулалтын алдаанууд нь хувийн хэвшлийнхэн санхүүжилтаа бууруулах үед эдийн засагт хэрэгтцээтэй санхүүжилтийг үргэлжлүүлэн олгодог Хөгжлийн банкуудыг хэрэгтцээтэй гэдгийг баталдаг. Иймэрхүү тохиолдолд зохицуулалтын асуудлуудыг шийдэхээр болон мөнгөний бодлогыг илүү үр ашигтай болгохын тулд төр оролцдог юм.

Циклийг сөрөх /countercyclical/ үүргийг мөн Арроу-Линдын санал болгосон эрсдлийн тархалт гэсэн дүгнэлт баталж байна. Төр нь /risk-neutral/ саармаг эрсдэл юм (эрсдэлийг цаг хугацаагаар болон бүлэг давхаргаар тараах чадварын дагуу), харин хувийн банкуудын эрсдэлээс зайлсхийлах нь нь цикл, мөчлөгийнх /банкууд эдийн засгийн циклийн оргил үедээ хангалуун байдаг ч тэдний эрсдэлээс зайлсхийлт нь циклийн байг алддаг/ байдаг бөгөөд эдийн засгийн уналтын үед төрийн эрсдэлийг шингээх үүргийн баталж өгч байна. Дэ ла Торре (2011) нар энэ төрлийн зах зээлийн уналт нь Хөгжлийн банкны үйл ажиллагаа хэрэгтэй байгаагийн шалтгаан болдог тухай санал дэвшүүлжээ.

Тусгай үүрэг бүхий Хөгжлийн банктай аж үйлдвэржсэн улсууд эдийн засгийн гол салбаруудад зээл олгохыг дэмжихийн тулд эдгээр байгууллагууд шаардлагатай гэж үздэг. Канадын эрх баригчид эдийн засгаа сэргээхийн тулд Хөгжлийн банкуудынхаа хөрөнгийг нэмэгдүүлж, санхүүжилт хүртэх боломж нь хязгаарлагдмал байж болох зээлээ төлөх чадвартай бизнесүүдийг дэмжин зээл олгох болон бусад төрлийн дэмжлэг үзүүлэх боломжийг тэдэнд олгосон. Үүнд нэмэлт зээл олгох, арилжааны банкуудтай хамтран синдикат болох болон адил хэмжээний зээл олгох, зах зээл дэх зээл болон төлбөрийн чадварыг нэмэгдүүлэхээр /securitization issues/ баталгаажсан үнэт цаас /хөрөнгөөр баталгаажсан өрийн бичиг, жишээ нь авто машин болон тоног төхөөрөмжийн лизинг гэх мэт/-ийг худалдаж авах зэрэг орно. Канадын засгийн газар нь Хөгжлийн банкиндаа зах зээлд 18 тэрбум ам.долларын нэмэлт зээлийг гаргах эх үүсвэрийг (2009 оны ДНБ-ны 2% орчим хувь болох) гаргаж өгсөн.

Зах зээлийн бүтэц дэх зайг /structural market gap/ нөхөх эхний үүрэг нь жижиг хэмжээний Хөгжлийн банкуудыг зорилтот салбаруудад анхаарлаа хандуулахыг уриалдаг байхад хоёрдох үүрэг нь боломжийн чадвартай болсон Хөгжлийн банкуудыг эдийн засагт зээлийн хязгаарлалтыг багасгахын тулд эрчимтэйгээр хөрөнгө оруулахыг уриалдаг байна.

Дээрх хоёр зорилтыг биелүүлэхийн тулд байгууллагын хөрөнгө нь ихээхэн хэмжээний өсөлт, балансад зохих хязгаарлалт хийхийг дэмжих цикл-д тохирон өөрчлөгдөх хэрэгтэй. Зарим улсын засгийн газрууд нь хямралын үед Хөгжлийн банкныхаа үйл ажиллагааг дэмжихийн тулд хөрөнгийг нь нэмэгдүүлэх зөвшөөрөл олгосон боловч байдал тогтвортой болсон үед энэхүү хөрөнгийг хэрхэн зарцуулах талаар заавар/заалтуудыг өгөөгүй байна. Хөгжлийн банкууд урьдын адилаар үйл ажиллагаагаа явуулж хувийн сектортой өрсөлдөнгөө шинээр орж ирсэн хөрөнгөө шинэ салбаруудад оруулан өргөжин тэлэх нь эрсдэл дагуулдаг аж. Нэгэнт зах зээл байнга өөрчлөгдөж байдаг тул шокийн дараагаар Хөгжлийн банкны чиглэл болон ач холбогдолийг өөрчилж болно.

Хөгжлийн банк байснаар зах зээлийн уналтыг бууруулах болно гэсэн үндэслэлийг авч үзсэнээр Хөгжлийн банкны урт хугацааны хөгжлийн хэрэгцээ нь түүний оршин тогтох баталгаа цаашид болохгүй бөгөөд Хөгжлийн банкны циклийг сөрсөн үүрэг нь зах зээл дээр тухайн байгууллага тасралтгүйгээр хязгаарлагдмал үйл ажиллагаа явуулахыг шаарддаг байна. Хувийн секторын эрсдлээс зайлсхийх байдал нэмэгдэх нь асуудлын гол шалтгаан бол Хөгжлийн банк нь зээл шууд олгох, зээлийн баталгаа гаргах, эсхүл зээл болон баталгаажсан үнэт цаас худалдан авахын аль нэгийг нь хэрэглэн эрсдлийг шингээхэд бэлэн байх шаардлагатай. Өөрийн үйл ажиллагаагаа нэмэгдүүлэхэд бэлэн байхын тулд Хөгжлийн банкнууд нь үйл ажиллагаа явуулж буй зах зээлээ сайн мэддэг болсон байхын зэрэгцээ туршлагатай мэргэжлийн боловсон хүчинтэй байх шаардлагатай.

Канадын Холбооны Зөвлөлөөс хямралын үеийн Хөгжлийн банкнуудын үүргийг судлаад дараахь дүгнэлтийг гаргасан:

Нэгэнт санхүүгийн хямрал нүүрлэсэн бол засгийн газруудаас буцаад зээлийн дэмжлэг үзүүлэх байгууллагын чадавхийг бүрдүүлэх нь дэндүү оройтсон хэрэг болно. Үйл ажиллагааны тодорхой чиг үүрэгтэй, туршлагатай мэргэжлийн ажилтнуудтай, түүнчлэн санхүүгийн хэрэгцээнд нийцсэн санхүүгийн чадавхитай, хувийн хэвшлийн зах зээл доголдоход өөрийнхөө үйл ажиллагааг нэмэгдүүлж чадах ийм байгууллагууд (Хөгжлийн банк) аль хэдийн байх ёстой аж.

Сүүлийн үеийн дэлхийн санхүүгийн хямрал нь хэрээсээ хэтэрсэн санхүүжилт, зээлийн сул шалгуур болон хувийн хэвшлийн банкуудын компанийн засаглалын уналттай холбоотой байсан бөгөөд зарим улсуудын улс төр нэн ялангуяа хямралын үед санхүүгийн салбарт төрийн оролцоо ихээхэн хэрэгтэй гэсэн чиглэлд өрнөж байна.

### **3. Хөгжлийн банкууд эдийн засгийн зорилтот салбарт үзүүлэх нөлөө**

Зах зээлийн эдийн засгийн нөхцөлд Хөгжлийн банкны үүргийг тодорхойлохдоо засгийн газраас зах зээлийн уналт руу анхаарлаа хандуулах нь түүний хийх ажлын эхний хэсэг болно. “Зай нөхөх” үзэл баримтлал нь Хөгжлийн банкны үүргийн гол санаа байх ёстой. Зах зээлийг нөхөн дүүргэх болон хувийн эзэмшлийн санхүүгийн байгууллагуудаас байнга эсхүл үе үе орхигдуулдаг салбаруудад санхүүгийн үйлчилгээ үзүүлэх зэрэгт үүргүүдээ чиглүүлсэн байх шаардлагатай. “

2009 онд Канадын Бизнесийн хөгжлийн банк нь олон улсын жишиг тогтоох судалгаа явуулсан. Дэлхийн 7 эдийн засгийн бүсийн 92 улсын засгийн газрын хөтөлбөрүүд болон дэлхийн улсуудын Хөгжлийн банкууд, Экспортын зээлийн агентлагууд, Хөгжлийн санхүүгийн байгууллага зэрэг 373 хөгжлийн байгууллагуудыг судалжээ. Энэ судалгаа нь санал болгож байсан бүх бүтээгдэхүүн, үйлчилгээг онцлон үзэж, тодорхой дүгнэлт гаргахын тулд баримтуудыг судалсан. Тэгээд Хөгжлийн банкуудын хамгийн нийтлэг 6 зорилтот зах зээл бол дараахь салбарууд гэж дүнэсэн байна. Үүнд:

1. Бичил-бизнес/эхэлж буй
2. Жижиг дунд үйлдвэр
3. Олон улсын худалдаа/даяарчлал
4. Орон сууцжуулалт
5. Дэд бүтэц
6. Хөдөө аж ахуйн салбар

Жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт:

Дэлхий дээр Хөгжлийн банкуудын хамгийн түгээмэл зорилтот зах зээл бол Жижиг дунд үйлдвэрлэл бөгөөд Хөгжлийн банкуудын 60%-аад хувь энэ зах зээлийг сонирхдог байна. Жижиг дунд үйлдвэрлэл гэж ерөнхийдөө 5-250 (5-аас бага бол бичил бизнес болно) ажилтантай үйлдвэрлэлийг хэлнэ. Дэлхийн хэмжээнд нийт аж ахуйн нэгжийн 95%-ийг ЖДҮ эзэлдэг бөгөөд тэдгээр нь ажил олгох гол эх үүсвэр, тухайн улсын эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгөгч хүч нь байдаг .

Худалдаа/даяарчлалын салбарт:

Хоёр дахь том зах зээл бол олон улсын худалдаа юм. Хөгжлийн банкуудын ойролцоогоор 45 хувь нь худалдааны салбарыг санхүүжилтийн зах зээл гэж үздэг. Эдийн засгийн хөгжлийн гол түлхүүр нь худалдаа байдаг ба ихэнх засгийн газруудад энэ салбарыг тэргүүлэх салбараа гэж үздэг. Хэдийгээр экспортлогчдын олонхи нь том үйлдвэрүүд байдаг ч, олон улсын худалдааны төвөгтэй байдалтай холбоотой эрсдлүүд нь худалдааны санхүүжилт авахад саад учруулдаг билээ. Үүнээс гадна худалдааны зах зээл нь том үйлдвэрээр хязгаарлагдахгүй бөгөөд ЖДҮ ч мөн олон улсын худалдааны боломжуудыг түргэн шаламгай мэдэрч, хөрөнгө оруулалтын болон худалдааны боломжуудыг ашиглаж чаддаг байх хэрэгтэй. Иймээс олон Хөгжлийн банкнууд ЖДҮ болон худалдааны зах зээлийг хоёуланг нь сонирхож тэдгээрийг тойруулан өөрсдийн бүтээгдэхүүнээ санал болгодог.

Орон сууцны зээлийн салбарт:

Хөгжлийн банкуудын сонирхдог бусад зорилтот зах зээлд эдийн засаг дахь орлого багатай хэсгийн орон сууцны моргейжийн санхүүжилтыг шийдвэрлэж, хот төлөвлөлт болон иргэдийн амьдралын таатай орчиныг шийдвэрлэж байна.

Дэд бүтцийн салбарт:

Хөгжлийн банкуудын зүгээс эдийн засагт үзүүлж байгаа томоохон үүрэг бөгөөд нөлөөлөл нь дэд бүтцийн төслүүдэд урт хугацааны их хэмжээний санхүүжилт олгож чаддаг оршдог. Төрийн оролцоо зайлшгүй шаардлагатай боловч төр нэг дор бүх санхүүжилтыг бүрэн гаргаж чадахааргүй, өөрөөр хэлбэл төсөвт дарамт учруулахаар дэмжээний томоохон санхүүжилт шаардлагатай төслүүдийг Хөгжлийн банкуудаар дамжуулан хэрэгжүүлж, төсвөөс үе шаттайгаар, урт хугацаатайгаар дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх бололцоо их байдаг.

Хөдөө аж ахуйн салбарт:

Үйлчилгээ явуулахад дэндүү үнэтэй тусдаг алслагдсан нутагт санхүүгийн үйлчилгээ үзүүлэх болон үр тарианы ургац хураалттай холбоотой гардаг эрсдлийн улмаас хөдөө аж, ахуйн салбарт хөрөнгө оруулах зэрэг нь ордог.

Хөгжлийн банкууд нь дан ганц зорилтот салбар эсвэл хэд хэдэн зорилтот салбарт зэрэг үйл ажиллагаа явуулдаг тусгай байгууллагууд байж болно. Хөгжлийн банк нь зөвхөн нэг зах зээлд төвлөрөх нь салбартайгаа ойр ажилладаг мэргэшсэн ажилтнуудтай байх давуу талтай бөгөөд өөрийн байр сууриа бий болгох, үүргээ нягт тодорхойлсон салбарын эксперт болох санаа нь хөгжлийн банкны мөрдлөгөө болгох хэтийн төлөв болон хүлээн зөвшөөрөгдөж байна. Гэхдээ энэ байр суурь нь банкны санхүүгийн тогтвортой байдлыг дэмжиж чаддаг байх шаардлагатай.

Санхүүгийн хямралын улмаас Хөгжлийн банкууд зорилтот салбараа огцом өөрчлөх хэрэггүй. Зорилтот салбарууд дэндүү өргөн хүрээтэй байдаг (ЖДҮ, орон сууцжуулалт, экспорт-импорт) тул Хөгжлийн банкууд зээлийн үйл ажиллагаагаа нэмэгдүүлбэл зээлийн асуудлууд багасч, эдийн засагт дэмжлэг үзүүлдэг. ЖДҮ-ээр дагнан ажилладаг Хөгжлийн банкыг хямралын үед тэднээс бага зэрэг том хэмжээний компаниудад үйлчилгээ үзүүлэх боломжтой гэж үзэж болох боловч энэхүү Хөгжлийн банк нь дэд бүтэц эсхүл хөдөө аж ахуйн салбарын хөгжлийг дэмжиж чадна гэж тооцоолж хэрэггүй.

Хөгжлийн банкуудын улсыхаа хөгжилд урт хугацааны турш гүйцэтгэсэн үүргийг богино хугацааны хөгжлийн эсрэг эдийн засгийн индикаторт гүйцэтгэсэн үүрэгтэй жишиж үзсэн.

- ✓ Нэгдүгээрт, зах зээлийн механизм үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон эдийн засгийн зарим секторт чиглэн үйл ажиллагаагаа явуулдаг жижиг хөгжлийн банкуудын зорилгын дагуу ажиллаж буй эсэх, зах зээлд ямар үүрэг, байр суурь эзэлж буй эсэхэд төрөөс тогтмол хяналт тавьдаг явдал буруу юм.
- ✓ Хоёрдугаарт, эдийн засгийн зээлийн хямралыг багасгах, бодлогын чанартай зах зээлд хөрвөх чадвартай үнэт цаас нийлүүлэх чадавхитай байх шаардлагатай. Тус байгууллагууд нь холбогдох салбарыхаа тухай хангалттай мэдээлэлтэй байж, тогтмол оролцоотой байснаар ямар ч тохиолдолд шаардлагатай арга хэмжээг авах бололцоо бүрдэх юм.

**Хүснэгт 2.Улс орнуудын Хөгжлийн банкуудын эдийн засгийн нөлөөний харьцуулалт**

№	Хөгжлийн банкны нэр	Байгуулагдсан он	Хөгжлийн банкны Эдийн засагт үзүүлэх нөлөө
1	Хөгжлийн төлөөх Оросын банк (Внешэконом банк)	1987	Эдийн засгийн өсөлтийг чангааж байгаа дэд бүтцийн салбарын бэрхшээлийг арилгаж, шинэтгэлийг дэмжих чиглэлийн засгийн газрын хөрөнгө оруулалтын төслийг санхүүжүүлдэг. Мөн тус банк Орон сууцны хорооллын барих зориулалтаар барилгын санхүүжилт зэргийг шийдвэрлэдэг.
2	Хятад улсын Хөгжлийн банк	1994	БНХАУ-ын Хөгжлийн банк нь 1994 оны 3 дугаар сард байгуулагдсан бөгөөд БНХАУ-ын төрийн зөвлөлийн шууд удирдлаган дор ажилладаг улсынхаа дунд болон урт хугацааны стратеги, бодлогыг дэмжих, БНХАУ-ын өрсөлдөх чадварыг сайжруулах, иргэдийн амьжаргааны төвшинг дээшлүүлэх зорилготой хөгжлийн санхүүжилтийн байгууллага юм. Үндэсний дэд бүтэц, үндсэн аж үйлдвэр, эрчим хүч, зам тээврийн салбарыг санхүүжилтээр хангаж эдийн өсөлтөнд нөлөөлж ирсэн. Мөн тус банкны харьяанд CDB орон сууцны санхүүжилтийн төвийг ажиллуулж, ипотекийн зээлийг олгож, ард иргэдийг орон сууцжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.
3	Солонгос улсын Хөгжлийн банк	1954	Аж үйлдвэрийн хөгжлийг хурдасгаж, үндэсний эдийн засгийг тэлэх зорилготой төслүүдийг удирдлага ба санхүүжилтээр хангаж ажилладаг. Улс төрийн нөлөөнөөс шалтгаалан дахин зохион байгуулсан. Солонгосын өнөөгийн өндөр хөгжилд үнэтэй хувь хувь нэмэр оруулсан томоохон хөрөнгө оруулалтуудыг хийсэн байдаг. Солонгосын Хөгжлийн Банкны санхүүжилтийн үр дүнд LG, Samsung, Hyundai, Posco болон Daewoo гэх мэт үндэстэн дамнасан аварга корпорациуд бий болсон. Солонгосын Хөгжлийн банк байгуулагдсан эхний жилүүдэд аж үйлдвэр, хими, хүнд үйлдвэрийн салбаруудад чиглэдэг байсан бол 1990-ээд оноос санхүүгийн зах зээл тэр дундаа хөрөнгө оруулалтын банкны салбарт хүч үзэх болсон. Солонгосын Засгийн газраас тус банкныг хувьчлах төлөвлөгөөг 2008 онд боловсруулснаар үйл ажиллагааны шинэ хэлбэрт шилжээд байна. Судлаачдын тайлбарлаж байгаагаар Солонгосын Хөгжлийн банкны тогтвортой, үр ашигтай, оновчтой үйл ажиллагааны үр дүнд Солонгос улс “ядуу буурай орон” – оос дэлхийн 10 дахь том эдийн засагтай улс болж чаджээ.
4	Казахстан улсын Хөгжлийн банк	2000	Казахстаны Хөгжлийн банк 2000 онд байгуулагдсан. Байгуулагдсан цагаас хойш тус улсын эдийн засагт хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Өнгөрсөн хугацаанд Казахстанын Хөгжлийн банк 12 тэрбум орчим ам.долларын өртөг бүхий төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлж, үүний үр дүнд шинээр 18.9 мянган шинэ ажлын байрыг болгосон. Казахстаны засгийн газраас баталсан аж үйлдвэрийн болон инновацийн салбарыг дэмжих хөтөлбөрийн (SPAID) хүрээнд дээрх салбарт 2.7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт оруулсан. Мөн байгууллагын үйл ажиллагаанд санхүүгийн олон улсын шилдэг туршлага, менежментийг нэвтрүүлэх тал дээр ихээхэн амжилттай ажиллаж байгаа бөгөөд санхүүгийн арга, хэрэгслүүдийг ашиглаж татан төвлөрүүлсэн төвлөрүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийн хэмжээ 8.6 тэрбум ам.долларт хүрсэн.
5	Германы KfW групп	1948	Жижиг дунд үйлдвэрлэл, орон сууцны санхүүжилт, боловсрол, дэд бүтцийн санхүүжилт, улс хоорондын экспорт, транзит, хүрээлэн буй орчин ба байгаль цаг уурын хамгааллыг идэвхижүүлэн, дэмжлэг үзүүлдэг.

6	Япон улсын Хөгжлийн банк	1999	Дотоод, гадаадын үйлчлүүлэгчдийг хөрөнгө оруулалт болон зээлийн цогц үйлчилгээгээр хангадаг. Улс төрийн нөлөөтэйгээр Төрийн өмчийн үйлдвэрүүдийг хэт дэмжсэн бодлого явуулж байснаас болж амжилтгүй ажилласан. Дайны дараахь үеийн сэргээн босголтын аж үйлдвэрийн явцад ихээхэн хувь нэмэр оруулж байсан хөгжлийн банкуудын нэг нь японы хөгжлийн банк байсан юм. Японы хөгжлийн банк нь 1999 оны 9-р сарын 30-нд татан буугдсан боловч, тухайн оны 10 дугаар сард шинэчилсэн үүрэг, зорилготойгоор шинэ банк болон зохион байгуулагджээ.
7	Тайваны хөгжлийн банк	1966	Банкны системийн нийт хөрөнгийн талыг эзэлдэг тул санхүүгийн системд хэт их нөлөө үзүүлсэн. Улс орны хөгжлийг дэмжих бодлого нь эцэстээ Тайванийн эдийн засагт өрсөлдөөнийг хязгаарлаж эхэлсэн.
8	Сингапур улсын Хөгжлийн банк	1968	Үндэсний болон олон улсын хэмжээнд санхүүгийн цогц үйлчилгээг үзүүлж, орон нутгийн хөгжлийг дэмжин, жижиг дунд үйлдвэрлэлийн өсөлтөнд дэмжлэг үзүүлдэг.
9	Мексикийн үндэсний санхүүгийн байгууллага (NAFIN)	1934	Мексикийн үндэсний санхүүгийн байгууллага (NAFIN) нь second-tier бизнесийн 75 хувийг эзлэх цахим сүлжээнд суурилсан хөрвөх факторингийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлснээрээ олонд танигдсан.
10	Төрийн Зээлийн байгууллага /Instituto de Credito Oficial, ICO/ (Испанийн төрийн банк)	1980	Тэрээр нийгэм, соёл, шинэчлэл эсхүл байгаль орчны нөхцөлтэй уялдуулан тэргүүлэх салбарууддаа анхаарлаа хандуулж байна. Түүнчлэн хувийн системийнхэн олгодоггүй эсхүл хэсгийг нь олгодог санхүүгийн хэрэгцээг хангахын тулд бусад санхүүгийн байгууллагуудтай зэрэгцэн ажилладаг. ICO нь өөрийн үйл ажиллагаагаа санхүүгийн тэнцвэртэй байдлын зарчмаар явуулдаг бөгөөд ажлын гүйцэтгэлээ өөрөө зохицуулдаг байгууллага юм. Сүүлийн үед ICO нь ЖДҮ-ийн санхүүжилтийг дэмжин эдийн засгийн урсгалыг сөрөх зарчмаар өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.
11	Монгол улсын Хөгжлийн банк	2011	МУХБ-наас авто зам, төмөр зам, уул уурхай, боловсруулах үйлдвэрлэл, цахилгаан станц, дэд бүтэц, орон сууц, тээвэр зэрэг эдийн засгийн тэргүүлэх салбаруудад зээл олгосон нь дунд болон урт хугацаанд улс орны хөгжилд бодитой эерэг нөлөө үзүүлж байна.



**Хөгжлийн банкуудын талаарх харьцуулсан судалгаа**

№	Бэлтгэ	Хятадын Хөгжлийн банк	Солонгосын Хөгжлийн банк	Японы Хөгжлийн банк
1	Компанийн засаглал			
2	Өмчийн хэлбэр	Хятадын хөгжлийн банкны хувьцааг БНХАУ-ын сангийн яам (36,54%), Central Huijin Investment Ltd (34,68%), Buttonwood Investment Holding Co., Ltd (27,19%), Нийгмийн хамгааллын сангийн үндэсний зөвлөл (1,59%) эзэмшдэг.	Төрийн өмчит 100%	Төрийн өмчит, Засгийн газар
3	Удирдлагын тогтолцоо	Хувьцаа эзэмшигчдийн хурал-Төлөөлөн удирдах зөвлөл-Гүйцэтгэх удирдлага гэсэн удирдлагын тогтолцоотой Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Хянан шалгах хороотой ба тус хороо нь ажил үүргийн гүйцэтгэлийг хянах, санхүү, дотоод аудитын ажлын албатай.	Хувьцаа эзэмшигчдийн хурал-Төлөөлөн удирдах зөвлөл-Гүйцэтгэх удирдлага гэсэн тогтолцоотой: Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Эрсдэлийн удирдлагын хороо, Гүйцэтгэх захирлын дэргэд Гүйцэтгэх удирдлагын хороо ажиллана. Гүйцэтгэх захирлын шууд удирдлагад Үйл ажиллагаа хариуцсан дэд захирал ажиллана.	Хувьцаа эзэмшигчдийн хурал-Төлөөлөн удирдах зөвлөл-Гүйцэтгэх удирдлага гэсэн удирдлагын тогтолцоотой Хувьцаа эзэмшигчдийн хурал, Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд Аудит, хяналтын зөвлөл, түүний ажлын алба байна. ТУЗ-ийн шууд удирдлагад ТУЗ-ийн зөвлөх, Тусгай хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа хяналтын зөвлөл, Үйл ажиллагааны аудитын хороо байна.
4	Салбар	БНХАУ-ын хөгжлийн банк нь 37 салбартай ба Хятадын эх газарт 3 салбар, Хонг Конгийн оффшор бүсийн 1 салбар, Кайр, Москва, Рио де Жанейро, Каракас, Лондон хотуудад 5 албан ёсны төлөөлөгчийн газартай.	Банк нь бүс нутгийн банкны 2 газартай. Тус газар нь бүс нутгийн толгой оффис болон далайн чанад дахь санхүүгийн төвтэй.	10 мужид өөрийн салбартай. 8 мужид төлөөлөгчийн оффистой. Хилийн чанадад 3 төлөөлөгчийн газартай, 3 охин компанитай.
5	Хянан нийцүүлэх	Гүйцэтгэх удирдлага нь Хуулийн газраас гадна Хянан нийцүүлэх газартай.	Үйл ажиллагаа хариуцсан дэд захирлын шууд удирдлагын дор Хянан нийцүүлэгч ажиллах Хянан нийцүүлэгчийн харьяанд Хуулийн алба, Хянан нийцүүлэх алба, Хэрэглэгчийн санхүүгийн мэдээллийг хамгаалах албууд ажилладаг.	Гүйцэтгэх удирдлагын дор Хууль зүйн асуудал эрхэлсэн хянан шалгах газартай. Энэ газар нь Зээлийн шинжилгээний газрын хамт нэг харьяа болдог.



## **VI. ХӨГЖЛИЙН БАНКУУДЫН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

Олон улсын туршлагаас үзэхэд тухайн улс орны хөгжилд хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд бие даан хэрэгжүүлэх боломжтой, улсын эдийн засгийн бүтцэд өөрчлөлт оруулахуйц, том хэмжээний төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх бодит үр дүнд хүрэх зорилгоор Засгийн газрын дэмжлэгтэй хөгжлийн санхүүгийн байгууллагыг байгуулдаг.

Дэлхийн 1, 2-р дайны дараа дайнд сүйдсэн улсууд эдийн засгаа сэргээн босгохын тулд хөгжлийн санхүүгийн байгууллага /Хөгжлийн банк/ байгуулах замаар урт хугацаатай, хүү багатай эх үүсвэр татан төвлөрүүлж, томоохон хэмжээний төслүүдийг амжилттай хэрэгжүүлсэн байдаг. Энэ үйл явц нь олон улсын санхүүгийн зах зээлд хөгжлийн банкууд үүсч байгуулагдах эхлэлийг тавьсан.

“Development Finance Institutions” буюу “Хөгжлийн Санхүүгийн Байгууллага”(ХСБ) гэж нэрлэгддэг эдгээр байгууллагын нэг хэлбэр нь хөгжлийн банк юм. Өнөөдөр дэлхий даяар үйл ажиллагаа явуулж буй 750 гаруй ХСБ байгаа бөгөөд тэднийг үндэсний хөгжлийн банк, хөгжлийн санхүүгийн корпораци, ЭксИм банк, хөдөө аж ахуйн банк гэхчлэн олон янзаар нэрлэдэг. Хөгжлийн банкууд нь нийгэм, эдийн засгийн томоохон үр нөлөө бүхий төслүүдэд урт хугацааны санхүүжилт олгохоос гадна судалгаа, зөвлөх үйлчилгээ болон техникийн туслалцаагч үзүүлж байна.

Хүснэгт 3. Хөгжлийн банкуудын эрсдэлийн удирдлагын зорилго

АНГИЛАЛ	УЛС	ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, БОДЛОГО
<b>ӨНДӨР ХӨГЖИЛТЭЙ</b>	Япон	<p>Үр ашигтай удирдлагын тогтолцоо, байгууллагын хэтийн төлөвт суурилсан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлдэг. Үйл ажиллагаанд учирч болох эрсдэлүүдийг судалж, эрсдэл бүрийг зохистойгоор удирдах нарийвчилсан, дэлгэрэнгүй эрсдэлийн удирдлагын бодлогыг хөгжүүлсэн.</p> <p>Хэрэгжүүлж буй эрсдэлийн удирдлага нь үйл ажиллагааны чухал хэсэг болдог бөгөөд ТУЗ-өөс баталсан нэгдсэн эрсдэлийн бодлоготой уялдаатай байдаг.</p>
	Канад	<p>Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх замаар Канадын ААН-үүдийн бизнес харилцааг дэмжихэд чиглэнэ.</p> <p>Үйл ажиллагаандаа хэрэгжүүлж буй эрсдэлийн удирдлагын нь харилцагч талуудад учирч буй эрсдэлийг удирдах, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад суурь болдог бөгөөд учирч буй эрсдэлийг удирдах, тайлбарлах нь байнгын тасралтгүй процесс байдаг. Эрсдэлийн удирдлагын хүрээнд risk appetite, шинээр хөгжиж буй эрсдэлийн бодлогуудыг хэрэгжүүлж, төрийн байгууллагуудаас тогтоосон хязгаарлалтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг. Эрсдэлийн удирдлага нь санхүүгийн секторын байгууллагуудад зайлшгүй учраас үйл ажиллагааны чиглэл бүрээр эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байна.</p> <p>ТУЗ-өөс эрсдэлийн удирдлагын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл, эрсдэлийн үзүүлэлтүүдийн хязгаарлалтыг тогтоодог.</p>
<b>ХӨГЖИНГҮЙ</b>	Бразил	<p>Байгууллагын үйл ажиллагааны дотоод хяналтыг сайжруулахын тулд зээл, зах зээл болон үйл ажиллагаанд учирч буй эрсдэлийг удирдах нэгдсэн эрсдэлийн удирдлагын бодлогыг хэрэгжүүлдэг. Эрсдэлийн удирдлагын хороо нь Ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон Эрхэлсэн захирлуудаас бүрддэг.</p> <p>Зээлийн эрсдэлийн удирдлага нь Бразилын хөгжлийн банк эрсдэлийн удирдлагаа хэрэгжүүлэх хязгаарлалтаа батлуулах суурь нь болдог бөгөөд нэг харилцагчийн болон зээлийн төвлөрөл нь эрсдэлийн гол хэмжүүр үзүүлэлт нь байдаг. Үйл ажиллагаанд баримтлах эрсдэлийн хязгаарлалтуудыг Бразилын төв банкнаас дүрэм журмын дагуу тогтоодог.</p> <p>Дотоод хяналтын тогтолцоо нь тус байгууллагын бүх түвшний үйл ажиллагааг хамардаг. Банкны хөрөнгийг хамгаалах, санхүүгийн мэдээллийн нарийвчлалыг сайжруулах, байгууллага үндсэн зорилгодоо хүрэхэд аюулгүй байдлыг хангахад чиглэдэг.</p> <p>Эрсдэлийн удирдлагын бодлого, дотоод хяналтын үйл ажиллагаа ТУЗ-өөс баталсан Байгууллагын дотоод хяналтын бодлого, Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага, Зах зээлийн</p>

		<p>эрсдэлийн удирдлага, Бизнес тасралтгүй байдлын удирдлагаар дамжин байгууллагын ажилчдад хүрч байдаг.</p>
<p><b>ХӨГЖИНГҮЙ</b></p>	<p>Орос</p>	<p>Внешэконом банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоо нь тус банкны санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн зохицуулалтын, арга зүйн, удирдлагын болон мэдээллийн технологийн шийдлийг багтаасан цогц систем байдаг. Эрсдэлийн удирдлагын хүрээнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Гадаад орчны шинжилгээ,</li> <li>- Банкны эрсдэлүүдийн тодорхойлох үнэлэх үйл ажиллагаа,</li> <li>- Үзүүлэлтүүдийн хязгаарлалтуудыг тогтоох,</li> <li>- Хянан нийцүүлэх үйл ажиллагаа,</li> <li>- Удирдлагын шийдвэр гаргалтыг дэмжих хүрээнд холбогдох мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.</li> </ul> <p>Зээлийн эрсдэлийн түвшинг холбогдогч талуудын санхүүгийн тайлан, барьцааны чанар болон зээлийн эрсдэлд нөлөөлөгч бусад хүчин зүйлсээс хамааруулж тооцдог.</p> <p>Зээлийн эрсдэлийн удирдлага нь эрсдэлийн түвшнийг хянаж, хязгаарладаг бүлэг үзүүлэлтүүдээс тогтдог бол зах зээлийн эрсдэлийг удирдахад гадаад валютын нээлттэй позиц, хөрвөх актив хэлбэрээр байршиж байгаа үнэт цаасны багцад үүсч болох эрсдэл гол үзүүлэлт болгон ашигладаг.</p> <p>Зах зээлийн эрсдэлийг үнэлэх, эрсдэлийн түвшинг тогтоохдоо хамгийн бага эрсдэлийн арга (VaR), мэдрэмжийн шинжилгээ (sensitivity analysis) болон стресс тестийг аргуудыг ашигладаг. Хөрвөх чадвар, хүү, ханшийн эрсдэлийн удирдлага нь банкны актив, пассивын удирдлагын бүрэлдэхүүн хэсэг бөгөөд бэлэн мөнгөний орох, гарах урсгал, хүү, болон валютын ханшийн мэдрэмжийн хувьд балансын тэнцвэртэй байдлыг хадгалахад чиглэдэг.</p> <p>Внешэконом банк нь 2015 онд эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаандаа ашиглаж байсан зохицуулалтын болон арга зүйн зарчмуудаа шинэчилж, шаардлагатай өөрчлөлтүүдийг холбогдох баримт бичгүүддээ тусгасан. Мөн мэдээллийн технологийн хувьд үүсэх эрсдэлүүдээс сэргийлэх үүднээс холбогдох ажлуудыг хийж байна.</p>
	<p>Хятад</p>	<p>Хятадын хөгжлийн банк нь 2015 оноос эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаагаа илүү өргөжүүлж, эрсдэлийн удирдлагын соёл, тогтолцооны асуудалд илүү анхаарал хандуулж эхэлсэн.</p> <p>Тухайн салбар, үйлчлүүлэгч болон улсын онцлогоос хамаарсан эрсдэлийн удирдах асуудлыг илүү чухлаар тавьж байгаа бөгөөд өөрийн салбар, нэгжүүдийн эрсдэлээс зайлсхийх, хяналтыг тасралтгүй сайжруулах, эрсдэлийн удирдлагын тайлагналын хэрэгжилтийг сайжруулахад хяналт тавьж байна. Эрсдэлийн удирдлагыг</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зээлийн эрсдэлийн удирдлага ба бодлого,</li> </ul>

<b>ХӨГЖИНГҮЙ</b>		<ul style="list-style-type: none"> <li>- Зээлийн эрсдэлийн ангилал, хэмжүүр үзүүлэлтүүд,</li> <li>- Зах зээлийн эрсдэл,</li> <li>- Үйл ажиллагааны эрсдэл,</li> <li>- Хянан нийцүүлэлтийн эрсдэл,</li> <li>- Дотоод хяналт зэргийн хүрээнд хэрэгжүүлж байна.</li> </ul>
<b>ХӨГЖИЖ БҮЙ</b>	Гана	<p>Эрсдэлийн удирдлагын нэгж нь банкны хяналтын үүргийг хэрэгжүүлдэг. Байгууллагын ашигт ажиллагааг хангах, хадгалахын тулд эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэхэд чиглэсэн эрсдэлийн удирдлагын бодлого хэрэгжүүлдэг.</p> <p>Тус банк нь 2009 оноос Basel-ийн стандартын дагуу эрсдэлийн үзүүлэлтүүдээ тооцоолж эхэлсэн. Basel-ийн стандартуудыг баримталж эхэлснээр эрсдэлийн үзүүлэлтүүдийн тооцоолол, мэдээллийн асуудал үйл ажиллагаа сайжирсан. Гана улсын Хөгжлийн банк нь эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг Зах зээлийн эрсдэлийн, Санхүүгийн эрсдэлийн, Үйл ажиллагааны эрсдэлийн болон Хянан нийцүүлэлтийн нэгж (Compliance unit)- эр дамжуулан хэрэгжүүлдэг.</p>
<b>ХӨГЖИЖ БҮЙ</b>	Боцвана	<p>Санхүүгийн зуучлалын үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой явуулахын тулд дараах эрсдэлүүдийг удирдаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Зээлийн эрсдэл/холбоотой талуудын эрсдэл</li> <li>- Хөрвөх чадварын эрсдэл</li> <li>- Зээлийн хүүгийн эрсдэл</li> <li>- Гадаад валютын ханшийн эрсдэл</li> <li>- Үйл ажиллагааны эрсдэл</li> </ul> <p>Эрсдэлээс зайлсхийх, үр ашигтай эрсдэлийн бодлого хэрэгжүүлэх нь ТУЗ-ийн үүрэгт хамаардаг. Санхүүгийн үзүүлэлтүүдийг тодорхойлох, хэрэгжилт, хяналт тавих, хувьцаа эзэмшигчдэд тайлагнах зорилгоор ТУЗ-өөс Аудитын хороо, Актив-пассивын удирдлагын хороог байгуулдаг. Аудитын хороо нь бодлогыг баталж, эрсдэлийн удирдлагын үзүүлэлтүүдийн хязгаарлалтыг тогтоодог.</p> <p>Ашигт ажиллагаа нь үйл ажиллагааны тогтвортой байдлыг илэрхийлэх учраас актив-пассивын удирдлагын хороо нь гадаад, дотоод зах зээлийн хүлээлт, стратегийн шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц хүчин зүйлсээс хамааруулж, урт хугацааны бодлого арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг шаарддаг.</p>
	Бангладеш	<p>Эрсдэлийн удирдлагын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Банкны эрсдэлийг үнэлэх тодорхойлох, эрсдэлийг бууруулах стратегиудыг томъёолох /ТУЗ-ийн шаардлагын дагуу Эрсдэлийн удирдлагын хороогоор банкны эрсдэлийн удирдлагын бодлогыг өөрчлөх эсэх асуудлыг авч хэлэлцдэг./,</li> </ul>

		<ul style="list-style-type: none"> <li>- Тухайлсан нэг эрсдэлийн хувьд шийдвэрлэх асуудлыг Эрсдэлийн дэд хороод дангаар болон хамтарсан байдлаар шийдвэрлэдэг бөгөөд Дэд хороодын үйл ажиллагааны хэрэгжилтэд улиралд нэг удаа хяналт тавьдаг.</li> <li>- Банкны рейтинг, CAMEL's rating-ийг өгсөхөд эрсдэлийн удирдлагын хүрээнд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааг боловсруулах, хэлэлцүүлэх,</li> <li>- Basel II-ийн дагуу тооцоолж буй үзүүлэлтүүд, стресс тест гэх мэт мэдээ, тайлангуудыг хянах, шинжлэх,</li> <li>- Хороодын үйл ажиллагааны тайлан, гарсан шийдвэрүүдийн улирлын тайланг нэгтгэж, ТУЗ-д тайлагнах,</li> <li>- ТУЗ-өөс өгсөн үүрэг, чиглэлд нийцүүлж, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэх,</li> <li>- Байгууллагын дотоод болон гадаад аудитуудын тайланг шалгах, шинжлэх, Аудитын шалгалтын дараа банкны мэдээ, мэдээллийн системийг уг шалгалтын дүнд нийцүүлэх.</li> </ul>
<p><b>ХӨГЖИЖ БУЙ</b></p>	<p>Казахстан</p>	<p>Эрсдэлийн удирдлага нь банкны соёлын салшгүй хэсэг юм.. Үндэсний зохицуулагчийн шаардлага болон Basel II-ийн зөвлөмжийн дагуу бүх түвшинд хийж гүйцэтгэдэг. Санхүүгийн зуучлалын үйл ажиллагааны тасралтгүй, тогтвортой явуулахын тулд дараах эрсдэлүүдийг удирдаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Макро эдийн засгийн эрсдэл</li> <li>- Улс төрийн эрсдэл</li> <li>- Санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл</li> <li>- Зээлийн эрсдэл</li> <li>- Бизнесийн эрсдэл</li> <li>- Хөрвөх чадварын эрсдэл</li> <li>- Өгөөжийн муруй эрсдэл</li> <li>- Хүүгийн эрсдэл</li> <li>- Валютын эрсдэл</li> <li>- Нэр төрийн эрсдэл</li> <li>- Төвлөрлийн эрсдэл</li> <li>- Санхүүгийн үйл ажиллагааны бус эрсдэл</li> <li>- Хууль зүйн эрсдэл</li> <li>- Төлөвлөгөөний эрсдэл</li> <li>- Өмчийн эрдэл</li> <li>- Үйл ажиллагааны эрсдэл</li> </ul>

## **VII. ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНКУУД ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХҮРЭЭНД УДИРДАЖ БУЙ ЭРСДЭЛҮҮД**

### **1. Гаднаад орчин:**

**Макро эдийн засгийн эрсдэл** – Үндэсний валютын ханшийн чангаралт, үнийн өсөлт зэрэг макро эдийн засгийн тогтворгүй байдалд хүргэх томоохон эрсдэлүүд

**Улс төрийн эрсдэл** – Улсын үндэсний язгуур ашиг сонирхолд тохиолдож болзошгүй эрсдэл.

**Гамшгийн эрсдэл** – Газар нутагт учрах хохирлын эрсдэл

**Зээлийн эрсдэл** – Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй зээлээ хугацаанд нь төлөөгүй тохиолдолд үүсэх боломжит алдагдлын эрсдэл

**Бизнесийн эрсдэл** – Материаллаг алдаанаас агуулгатай, энэ ойлголт нь материаллаг алдааг дотроо агуулна. Бизнесийн эрсдэл нь Банкны иж бүрдлийн өөрчлөлтөөс эрсдэл гарч болзошгүй юм. Тухайлбал: зах зээлд амжилт олохгүй бүтээгдэхүүн гаргах, зах зээлийн үл тохирох байдал, өр төлбөрт хүргэх эсвэл нэр хүндийн эрсдэлд учруулж болох алдаа дутагдал гаргасны улмаас бизнесийн эрсдлийг ойлгох нь материаллаг алдаа гарах магадлалыг тогтооход чухал ач холбогдолтой.

**Хөрвөх чадварын эрсдэл** – Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ алдагдаагүй боловч харилцагчийн өмнө хүлээсэн үүргээ цаг тухайд нь биелүүлэх чадваргүй болох эсвэл тухайн үүргийг биелүүлэхэд ихээхэн хэмжээний зардал гарах нөхцөл бадлыг үүсгэхийг хэлнэ. Хөрвөх чадварын эрсдэл нь санхүүгийн байгууллагийн өдөр бүрийн үйл ажиллагаатайгаар холбоотойгоор үүсэн бий болдог эрсдэл юм.

**Төвлөрлийн эрсдэл** – Тодорхой ангилалд хэт их мөнгө зээлэх эрсдэл

### **2. Дотоод орчин:**

**Санхүүгийн үйл ажиллагааны бус** – Санхүүгийн бус бүх болзошгүй бүх эрсдэлүүд

**Өгөөжийн муруй эрсдэл** – Зах зээлд арилжаалагдаж байгаа, хугацаагаараа ялгаатай тогтмол орлоготой үнэт цаасны өгөөжүүдийн зах зээлийн хүүний түвшний сөрөг нөөлөөллийн эрсдэл.

**Хүүгийн эрсдэл** – Зээлийн хүүг зах зээлд эрэлт хэрэгцээ, ханшын өөрчлөлт, харилцагчийн ашигт ажиллагааны түвшин зэргээс хамааруулалгүйгээр өндөр тогтоосон, хадгаламжийн хүүд тухайн банк бодит байдлаас өндөр хүү төлсөн зэргээс хүүгийн орлого нь зардлаа нөхөх бололцоогүй болж учрах алдагдал юм.

**Валютын эрсдэл** – Гэрээ, хураамжийн тооцоонд ашигласан мөнгөн тэмдэгтээс өөр мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн байх зэрэг шалтгаанаар үүсдэг эрсдэл. Аль нэг валютын өөр валюттай харьцах харьцаа өөрчилснөөс үүсдэг эрсдэл буюу гадаад валютын ханшийн өөрчлөлөөс үүсэх эрсдэл.

**Өмчийн эрсдэл** – Өмчийн үнэт цаасны сөрөг үнэлгээний санхүүгийн алдагдлын эрсдэл

**Үйл ажиллагааны эрсдэл** – Санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагаа явц дундаа хангалтгүй улмаас учрах алдагдлын эрсдэл

**Төлөвлөгөөний эрсдэл** – Байгаль орчин, нийгэм, (үнэт чанар, хүмүүсийн зан төлөв, нийгмийн бүтцийн өөрчлөлт) улс төр (улс төрийн тогтворгүй байдал), хууль зүйн орчин, эдийн засгийн нөлөөлөл (олон улсын эдийн засгийн байдал), хувь хүний үйл ажиллагааны орчинтой холбоотой үүсэх байгаль, нийгмийн эрсдэл юм.

**Хууль зүйн эрсдэл** – Хууль тогтоомжийн шаардлагыг мөрдөөгүй улмаас үүсэх эрсдэл

**Дагаж мөрдөх эрсдэл** – Хууль дагаж мөрдөх дутагдлын улмаас үүсэх нэр хүнд, материал ба санхүүгийн алдагдал үүсэх эрсдэл

**Нэр төрийн эрсдэл** – Олон нийтийн сөрөг бодол, банкны найдвар алдсан таагүй үр дүнээс үүсэх эрсдэл.

*Зураг 5. Хөгжлийн банкуудын эрсдэлийн удирдлагын хүрээнд удирдаж буй эрсдэлүүд*



## VIII. АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Armendáriz De Aghion, B. "Development Banking" Journal Of Development Economics 58: 83-100, 1999.

Boskey, S. (1959) Problems And Practices Of Development Banks, Baltimore, Johns Hopkins University Press

Bruck, N. 1998. "The Role Of Development Banks In The Twenty-First Century." Journal Of Emerging Markets 3: 39-67.

Bruck, Nicholas, "Development Banking, Concepts And Theory", Idea 2003.

Armendáriz De Aghion, B. 1999. "Development Banking" Journal Of Development Economics 58: 83-100.

Diamond, W. 1957 Development Banks, Baltimore, Johns Hopkins University Press

Galindo, Arturo And Alejandro Micco (2004) "Do State-Owned Banks Promote Growth? Cross-Country Evidence Fro Manufacturing Industries," Economic Letters 84: 371-376.

Kane, J. (1975) Development Banking, Lexington Books

Iqbal, F. & Riad, E, "Commercial Microfinance In Egypt - The Case Of The National Bank For Development." Case Study, World Bank 25 May 2004.

La Porta, R., F. López-De-Silanes, And A. Shleifer. "Government Ownership Of Banks." Journal Of Finance 57: 265-301. 2002.

Panizza Ugo, Eduardo Levy-Yeyati, Alejandro Micco "Should The Government Be In The Banking Business? Therole Of State-Owned And Development Banks," Working Papers 1014, Inter-American Development Bank, Research Department, 2004.

Standard & Poor's, "National Development & Export Credit Institutions", June 2004.

Rethinking The Role Of National Development Banks, United Nations, Department Of Economic And Social Affairs, Financing For Development Office

## АШИГЛАСАН ЦАХИМ ХУУДАС

<http://www.dbj.jp/en/>

<https://www.kdb.co.kr/ih/simpleJsp.do>

<http://www.cdb.com.cn/English/>

<http://www.afdb.org>